



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ULAANBAATAR CITY HEALTH DEPARTMENT

НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2023

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар

Шуудангийн хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн засаг захиргааны III байр.

Энэхүү эмхтгэлийн талаархи саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.

Утас: 77990101

Э-шуудан: Info@ubhealth.mn,nemg.statistic2020@gmail.com

Вебсайт: <http://www.emg.ub.gov.mn>

Эрхэлсэн: П. Эрхэмбулган, Эрүүл мэндийн газрын дарга

Хянасан: Д.Сайнхүү,

Төлөвлөлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Эмхэтгэсэн: Ц.Сонгиносүрэн, ТХШҮДАХ-ийн ахлах мэргэжилтэн

Ш.Мөнхзул, ТХШҮДАХ-ийн ахлах мэргэжилтэн

Б.Отгонжаргал, ТХШҮДАХ-ийн ахлах мэргэжилтэн

Г.Нямсүрэн, ТХШҮДАХ-ийн мэргэжилтэн

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт	4
Өмнөх үг	5
Хураангуй үзүүлэлт.....	6
Бүлэг I.ХҮН АМ	7-13
Монгол Улсын хүн ам (Улаанбаатар хотын хүн ам).	7-8
Хүн ам зүйн үндсэн үзүүлэлт	8-10
Тогтвортой хөгжил	11-13
Бүлэг II. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ	14-28
Жирэмсний хяналт ба төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ	14-15
Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ.....	16-18
Төрсний дараах үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ.....	19-20
Эхийн эндэгдэл	20-21
Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэглээ.....	21-22
Үр хөндөлт.....	22-23
Хүүхдийн эрүүл мэнд	23-24
Нялхас болон 5 хүртэлх насны хүүхэд, өсвөр насны хүүхдийн эндэгдэл	24-28
Бүлэг III. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ	29-44
Амбулаторийн тусламж, үйлчилгээ	30-33
Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	33-35
Эмнэлгийн тусламж үйлчилгээ шатлалаар	35-44
Бүлэг IV. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ХҮНИЙ НӨӨЦ.....	44-47
Бүлэг V.ХАЛДВАРТ ӨВЧИН.....	48-58
Амьсгалын замын халдвар	49-53
Гэдэсний халдвар	54-55
Бэлгийн замаар дамжих халдвар.....	55-58
Бүлэг VI. ХАЛДВАРТ БУС ӨВЧИН	59-89
Хүн амын нийт өвчлөл	59-69
Хүүхэд өсвөр үеийнхний өвчлөл	69-71
Хорт хавдрын өвчлөл.....	72-76
Халдварт бус өвчний эрт илрүүлэг	77-78
Сэтгэцийн эрүүл мэнд.....	79-80
Хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөл.....	80-82
Бүлэг VII. ХҮН АМЫН НАС БАРАЛТ	83-89
Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан	83-84
Хорт хавдрын нас баралт	84-87
Осол гэмтлийн нас баралт	88-89
Бүлэг VIII. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	90-94
Бүлэг IX. ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НОМХОН ДАЛАЙН БАРУУН БҮСИЙН МЭДЭЭНИЙ САНД ОРДОГ ҮЗҮҮЛЭЛТ, УЛААНБААТАР ХОТ	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн хөгжлийн банк
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ВХА	Вируст гепатит А
ВХВ	Вируст гепатит В
ВХС	Вируст гепатит С
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДОТС	Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ
ЖСА	Жирэмслэлтээс сэргийлэх арга
НБЕК	Нас баралтын ерөнхий коэффициент
НЭМ	Нийгмийн эрүүлмэнд
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НД	Налайх дүүрэг
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ОЭТС	Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ
ӨОУА	Өвчний Олон Улсын ангилал
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТЕК	Төрөлтийн ерөнхий коэффициент
ТНК	Төрөлтийн нийлбэр коэффициент
ТТК	Төрөлтийн тусгай коэффициент
УБ	Улаанбаатар
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УГТЭ	Улсын гуравдугаар төвэмнэлэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХБНЭ	Хорих байгууллагын нэгдсэн эмнэлэг
ХХЭМБ	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЭМҮТ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ / DATA SUMMARY

Үзүүлэлт	Монгол Улс	Улаанбаатар хот
Хүн ам		
Нийт	3.504.7	1734.8
Үүнээс: эрэгтэйчүүдийн эзлэх хувь	49.0	49.4
эмэгтэйчүүдийн эзлэх хувь	51.0	51.6
ТЕК	19.0	21.2
ТНК	2.7	2.6
НБЕК	5.2	5.5
Цэвэр өсөлт	13.8	15.7
Дундаж наслалт	71.5	72.2
Эх хүүхдийн эрүүл мэнд		
Төрсөн эх	63915	34044
Амьд төрсөн хүүхэд	64306	34298
Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөд	26.4	37.9
Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	12.3	13.7
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	14.9	15.7
Амьгүй төрөлтийн түвшин	5.3	6.1
Жирэмсний эрт хяналтын хувь	92.2	90.4
Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ		
Дундаж ор хоног	6.8	6.7
Орны эргэлт	35.6	37.8
Орны фонд ашиглалтын хувь	66.5	69.0
Хүний нөөц		
10000 хүн ам ногдох их эмч	44.3	60.9
10000 хүн амд ногдох сувилагч	42.8	48.8
10000 хүн амд ногдох эмнэлгийн мэргэжилтэн	195.9	243.0
Эмч/сувилагчийн харьцаа	1.0:1.0	1.0:0.8
Нэг эмчид ногдох хүний тоо	225.8	164.2
Эрүүл мэндийн байгууллага		
Нийт ЭМБ	4746	2540
Үүнээс: Өрхийн эрүүл мэндийн төв	224	148
Тосгоны эрүүл мэндийн төв	16	4

БҮЛЭГ I. ХҮН АМ

1.1. ХҮН АМ

Монгол Улсын хүн ам 1921 онд 649,9 мянга, 1962 онд 1 сая хүн амтай болж, 1988 онд 2 сая дахь иргэнээ өлгийдөн авсан бол 2015 онд 3 сая хүн амтай болон хүн амын өсөлт тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Монгол улсын хүн амын тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 3 сая 504.7 мянга болж, өмнөх оноос 47.2 мянган хүнээр буюу 1.4 хувиар өссөн байна. Нийт хүн амын 68.4 хувь нь хот суурин газар, 31.6 хувь нь хөдөө амьдарч байна.


Хүн амын 49.0 хувийг эрэгтэйчүүд, 51.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрчүүдийн тоо 96 байна. 983.5 мянган өрх амьдарч байгаа ба дунджаар 1 өрхөд 3.5 хүн ногдож байна.

Улаанбаатар хотын 4,704.4 км² нутаг дэвсгэрт нийт хүн амын 49.5 хувь нь оршин сууж байна. 2023 оны байдлаар Улаанбаатар хотын суурин 1734.8 мянган хүн ам 9 дүүрэгт оршин сууж байгаа ба өмнөх оноос 47.2 мянган хүнээр буюу 1.4 хувиар өссөн.


Нийслэлийн хүн амын 48.4 хувийг эрэгтэйчүүд, 51.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба хүйсийн харьцаа 100 эмэгтэйд 93.6 эрэгтэй ногдож байна. Насны бүтцээр авч үзэхэд 15 хүртэлх насны хүүхэд 31.6 хувийг, 15-19 насны хүүхэд 6.6 хувийг, 20-64 насны хүн ам 55.4 хувийг, 65 дээш насны хүн ам 5.0 хувийг тус тус эзэлж байна. Улаанбаатар хотод 100-аас дээш настай 36 өндөр настан амьдарч байгаагаас 30.5 хувь нь эрэгтэй, 69.5 хувийг эмэгтэй ахмад настан эзэлж байна.

Улаанбаатар хотод 2023 оны байдлаар 465.1 мянган өрх амьдарч байгаа ба дунджаар 1 өрхөд 3.5 хүн ногдож байна.


Улаанбаатар хотын суурин хүн амын тоо, сонгосон оноор, сая.хүн



Улаанбаатар хотын суурин хүн ам, дүүргээр, 2023 он



Улаанбаатар хотын өрхийн тоо, дүүргээр, 2023 он




1.2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ, ДУНДАЖ НАСЛАЛТ

Цэвэр өсөлт

Хүн амын цэвэр өсөлтийн түвшин нь хүн амын тооны өөрчлөлтийг 1 000 хүн амд харьцуулсан үзүүлэлт юм. Уг үзүүлэлт нь хүн амын дундаж наслалтыг тооцох, хүн амын хэтийн төлөвийг тооцох, хүн амын талаар төрөөс баримтлах бодлогын үр дүнг үнэлэх, улс орны хөгжлийн тогтвортой байдлыг үнэлэхэд ашиглана.

Улаанбаатар хотод 2022 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 23.2 байсан бол 2023 онд 21.2 болж 2.0 пунктээр буурсан байна.

Хүн ам зүйн үзүүлэлт, сүүлийн 10 жилээр



Хүн ам зүйн үндсэн үзүүлэлт, сүүлийн 10 жилээр

Он/ Year	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Насны бүлгээр /хувиар/ (%)										
Эмэгтэйчүүдийн эзлэх хувь/ (%)	52.2	51.6	52.1	52.1	51.6	51.6	51.7	50.9	51.7	51.6
0-15 хүртэлх нас/	26.8	29.7	29.4	29.9	31.4	32.4	33.0	32.1	32.9	32.9
15-64 нас/ 15-64	69.1	66.4	66.7	66.1	64.6	63.3	62.5	63.4	62.3	61.9
65-аас дээш/	4.0	3.8	3.9	4.0	4.0	4.3	4.5	4.5	4.8	5.2
Хүн ам зүйн коэффициентууд										
ТЕК	30.6	30.2	27.5	27.4	28.4	28.5	26.3	24.5	23.1	21.2
НБЕК	5.5	5.4	5.1	5.2	5.7	5.4	5.1	7.0	6.1	5.5
Цэвэр өсөлт	25	24.9	23.7	22.3	22.7	23.1	21.2	17.5	17.0	15.7

Хүн ам зүйн үзүүлэлт, дүүргээр, 2023 он

№	Үзүүлэлт	БГД	БЗД	СХД	СБД	ХУД	ЧД	НД	БНД	БХД	УБ дундаж	Эх сурвалж
1	Газар нутгийн хэмжээ (1000 км2)	29.49	1.244.12	1.200.63	208.4	484.66	89.3	687.6	620.2	140	4.704.4	НСГ
2	Хүн амын тоо	252979	436822	341390	141537	258187	136280	40238	28926	4422	1640781	НСГ
Хүн амын тоо насны бүлгээр (%)												
3	0–4 нас	10.2	10.6	10.8	9.4	11.5	9.4	10.5	9.7	10.4	10.5	НСГ
	5–14 нас	22.7	22.3	22.3	21.4	23.7	21.1	22.0	21.3	21.0 ₁	22.4	НСГ
	65 дээш нас	5.5	4.5	4.7	6.5	4.8	6.0	5.5	6.0	6.5	5.1	НСГ
4	Төрөлтийн түвшин (1000 хүн амд)	15.1	16.6	18.6	15.1	19.6	16.5	19.6	27.3	14.2	21.2	НЭМГ
5	Нас баралтын түвшин (1000 хүн амд)	3.7	4.0	5.1	5.3	3.6	6.1	6.4	8.9	3.2	5.5	НЭМГ
6	Цэвэр өсөлт	11.4	12.6	13.5	9.8	16	10.4	13.2	18.4	11	15.7	НЭМГ
7	Төрөлтийн тусгай коэффициент (15-49 насны эмэгтэйчүүд)/	57.5	64.4	75.3	60.2	75.6	68.1	81.2	66.4	63.6	82.7	НЭМГ

Дундаж наслалт

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь хүний хөгжлийн индексийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд 2023 оны байдлаар Монгол улсын хүн амын дундаж наслалт нь 71.5 болж өмнөх оны түвшингээс 0.5 жилээр нэмэгдсэн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 76.9, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.6 жил байна.

Дундаж наслалтын хувьд хүйсийн ялгаа аль ч улс оронд байдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 5.4 насаар илүү бөгөөд манай улсын хувьд 9.2 жилээр, Улаанбаатар хотын хувьд 8.1 жилээр илүү байна.


Улаанбаатар хотын хүн амын дундаж наслалт 72.2 үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.5, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.6 байгаа нь эрэгтэйчүүдийн амьдрах хугацаа эмэгтэйчүүдийнхээс 8.2 жилээр бага байна.

Аливаа улсын хүн амын дотор залуу насны хүн амын эзлэх хувь их байвал хүн ам зүйн шинжлэх ухаанд залуу хүн амтай улс гэж үздэг. Ихэнх хөгжиж байгаа орнуудад хүн амын бараг хагас нь 15-аас доош насныхан, 10-15 орчим хувь нь 65 буюу түүнээс дээш насныхан байдаг.

Манай орны хувьд 2023 оны байдлаар 15-аас доош насныхан 32.3 хувь, 65 буюу түүнээс дээш насныхан 4.9 хувийг эзэлж байгаа бол Улаанбаатар хотын хувьд 15-аас доош насныхан 31.1 хувь, 65 буюу түүнээс дээш насныхан 6.15 хувийг эзэлж байна.

Хүн амын нас, хүйсийн суварга

Хүн амын нас, хүйсийн суварга нь цаг хугацааны тодорхой үеийн хүн амын нөхөн үржихүйн тасралтгүй процессын явцыг харуулна. Хэрэв хүн амын нөхөн үржихүйн процессын тухайлбал төрөлт, нас баралтын түвшинд ямар нэг өөрчлөлт гараагүй тохиолдолд насны суварга нь тэнцүүхэн дүрслэгдэх ба урт хугацааны туршид төрөлтийн өндөр түвшин хадгалагдаж, нас баралтын түвшин ч харьцангуй өндөр байсан тохиолдолд суваргын суурь нь өргөн, орой руугаа нарийссан хэлбэртэй, харин төрөлт, нас баралтын түвшин бага байсан тохиолдолд суурь нь нарийхан, орой руугаа өргөссөн хэлбэртэй байна.



2003 болон 2023 оны хүн амын нас, хүйсийн суваргыг харьцуулахад 2003 онд харьцангуй пирамид хэлбэртэй байхад 2023 оны суварга нь дунд хэсгээрээ аажмаар өргөсөж байгаа нь Улаанбаатар хотын хүн амын дийлэнх нь идэр насны хүн ам эзэлж, хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж хүн ам зүйн цонх үе үргэлжлэхийг харуулж байна. Сүүлийн жилүүдэд төрөлт тогтвортой нэмэгдэж 0-4, 5-9 насны хүн ам их байгаа нь суурь өргөн бүтэцтэй байгааг харуулж байна.

1.3 “АЛСЫН ХАРАА-2050” ХӨГЖЛИЙН БОДЛОГО

“Тогтвортой хөгжил-2023 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан. Тогтвортой Хөгжлийн зорилго нь 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болсон Мянганы хөгжлийн зорилтын үргэлжлэл бөгөөд 2015 оны 9-р сард НҮБ-ын дээд хэмжээний 70 дугаар чуулганаар 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг батлан гаргаж тус зорилтын үрэлжлэл болох Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацаан хөгжлийн бодлогыг Монгол Улсын их хурлын 2020 оны 52-р тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 3 үе шаттай бөгөөд I үе шат (2021-2030), II үе шат (2031-2040), III үе шат (2041-2050) онд хэрэгжинэ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2 дугаар зүйл Хүний хөгжлийн бодлогот “Эрүүл мэнд”-ийн зорилтыг дэвшүүлсэн тавьсан.

Зорилт 2.2. Эрүүл мэндийн дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.

Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

I үе шат (2021-2030): Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийг үе.

II үе шат (2031-2040): Амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэн төлөвшүүлэх үе.

III үе шат (2041-2050): Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих үе.

I үе шат (2021-2030): Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе:

1. Иргэн, гэр бүл ажил олгоогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо бэхэжсэн байна.
2. Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна.
3. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдсэн байна.
4. Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулсан байна.
5. Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрагдах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйл буурсан байна.
6. Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, нийт сумыг хамарсан алсын зайн үндэсний сүлжээг бий болгож, хүн амын дундаж наслалт уртассан байна.
7. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, зүрх судасны өвчлөлөөс болон хорт хавдраас шалгаалсан нас баралт буурсан байна.

Товлолт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, вирус гепатитын өвчлөл, сүрьеэгийн тохиолдлыг бууруулсан байна.

Сүрьеэ болон вирус гепатитийн өвчлөл, 10000 хүн амд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2025	2030
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 10000 хүн амд														
Улсын дундаж	13.9	14.2	14.1	14.1	13.1	12.4	11.0	11.2	10.2	7.1	6.9	7.0	14 ^a	13 ^a
УБ хот	19.1	19.7	20.4	19.7	18.6	16.6	14.8	14.7	14.1	9.6	8.5	9.0	-	-
Сүрьеэгийн нас баралтын түвшин, 10000 хүн амд														
Улсын дундаж	24.1	8.8	3.9	2.9	1.8	1.7	1.5	1.6	1.3	0.4	0.6	0.3	2.5 ^a	2 ^a
УБ хот	23.0	9.9	4.9	4.1	2.6	2.4	2.0	1.6	1.0	0.4	0.8	0.4	-	-

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай, 2016

8. Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буурсан байна.

Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2025	2030
Улсын дундаж	30.6	26.0	48.6	26.9	27.1	23.0	30.2	94.9	35.1	26.4	20.0 ^a	15.0 ^a
УБ хот	35.9	28.8	41.8	31.2	29.5	24.3	27.7	118.1	28.4	37.9	-	-
Аймгийн дундаж	25.0	23.0	56.0	22.3	24.4	21.6	32.9	70.9	42.8	13.3	-	-

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай, 2016 Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд),

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2025	2030
Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд													
Улсын дундаж	14.6	15.3	15.3	16.8	13.6	13.4	13.3	13.7	11.6	12.4	12.3	11 ^a	8 ^a
УБ хот	13.6	15.0	14.7	15.0	12.7	13.6	12.9	13.2	11.1	12.5	13.7	-	-
Аймгийн дундаж	15.7	15.7	15.9	18.8	14.5	13.1	13.8	14.3	12.0	12.3	10.8	-	-
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд													
Улсын дундаж	18.0	18.4	18.3	20.8	16.7	16.9	16.1	14.0	13.9	15.5	14.9	12 ^a	9 ^a
УБ хот	16.3	17.8	17.3	18.2	15.4	16.1	14.9	13.4	13.1	14.9	15.7	-	-
Аймгийн дундаж	19.7	19.0	19.2	23.7	18.1	17.7	17.6	14.6	14.7	16.2	14.1	-	-

Эх үүсвэр: а. Монгол Улсын Их Хурлын тогтоол 19, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай, 2016

БҮЛЭГ II. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/760 дугаар тушаалаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд 2021-2024 онуудад Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг тогтвортой бууруулах зорилт тавьсан байна.

2.1. ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТ, ТӨРӨХИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Жирэмсэн үеийн хяналт нь эх, ургийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлт хүчин зүйлүүдийг цаг алдалгүй илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эсэн мэнд амаржуулах, төрсний дараах үед тусламжийг цаг алдалгүй үзүүлэхэд чиглэгддэг нэн чухал тусламж, үйлчилгээ юм.

ДЭМБ-аас жирэмсэн үеийн хяналтад дундажаар найман удаа хамрагдсан байхыг зөвлөмж болгосон ба цусны даралт хэмжих, шээсэнд бактери, уураг илрүүлэх шинжилгээ, тэмбүү болон далд хэлбэрийн цус багадалтыг илрүүлэх цусны шинжилгээ, жин/өндрийн хэмжилт зэрэг тусгайлсан үйлчилгээг зөвлөмж болгодог.

Манай улсад хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг 6 удаа, өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг 8 удаа үзүүлэхийг зөвлөдөг бөгөөд эх жирэмсэн болсноо мэдмэгц 12 долоо хоногоос дотогш хугацаанд эхний үзлэгт хамрагдахыг шаарддаг.


Төрөхийн өмнөх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь жирэмснийг эрт илрүүлж, жирэмсэн эмэгтэйчүүдийг жирэмсний эрт үед хяналтад авч, жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа эмчийн хяналтад хамруулах, жирэмсэн эхчүүдийг цусны ерөнхий шинжилгээ, БЗДХ-ын шинжилгээнд бүрэн хамруулах нь цус багадалт, жирэмсний хожуу хордлого, бөөрний эмгэг, ургийн болон бусад эмгэгийг эрт илрүүлж, жирэмслэлт төрөлтийн хүндрэлээс сэргийлэх, хүндрэлийг эрт илрүүлж цаг алдалгүй эмчлэх, хавсарсан өвчнийг оношлох, эмчлэх мөн жирэмсний болон төрөх үеийн хүндрэлийг бууруулахад чиглэгдэж байна.

2.1.1. Жирэмсний хяналт

2023 оны жилийн эцсийн байдлаар НЭМГ-ын дүүргийн эрүүл мэндийн төвд, ЭНЭҮТ-д нийт жирэмсний хяналтад 31791 эмэгтэй хамрагдсанаас 91.6 хувь нь жирэмсний эхний 3 сартайд, 7.5 хувь нь 4-6 сартайд, 0.9 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад хамрагдаж байна.

Жирэмсний эрт хяналтын хувь 91.5 хувь болж, өмнөх оноос 0.1 хувиар буурсан нь улсын дунджаас 0.6 хувиар, аймгийн дунджаас 1.4 хувиар бага үзүүлэлттэй байна. Жирэмсний эрт хяналтын хувь Баянзүрх, Багануур, Багахангай дүүрэгт Нийслэлийн дунджаас бага байна.

Жирэмсний эрт хяналтын хувь, дүүргээр, 2022-2023



НЭМГ-ын харъяа эрүүл мэндийн байгууллагад хяналтанд хамрагдсан нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 97.9 хувь нь цусны шинжилгээ хийлгэснээс 4.1 хувь нь цус багадалттай байгаа нь улсын дунджаас /3.9/ 0.2-оор, аймгийн дунджаас /3.8/ 0.3-аар тус тус их байна.

Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.8 хувь нь тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд хамрагдсанаас 2.3 хувьд нь тэмбүү өвчин илэрсэн ба энэ үзүүлэлт нь улсын дунджаас 0.2 хувь их байна. БГДЭМТ 2.0, СХДЭМТ 2.0, ЧДЭМТ 3.6, СХДНЭ 2.4 хувь байгаа нь Нийслэлийн дундаж үзүүлэлтээс 0.4-2.0 хувиар их байна.


Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.7 хувь нь хамрагдсанаас 0.1 хувьд нь заг хүйтэн илэрч улсын дундажаас 0.1 хувиар бага байна. СХДЭМТ 0.2, ЧДЭМТ 0.2, НДЭМТ 0.4, СХДНЭ 0.2 хувийг тус тус эзэлж Нийслэлийн дундаж үзүүлэлтээс 0.1-0.2 хувиар их байна.

Трихомониаз илрүүлэх шинжилгээнд жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.7 хувь нь хамрагдсанаас 1.1 хувь нь эерэг гарч улсын дундажаас 0.1 хувь бага байна. БГДЭМТ 1.3, БЗДЭМТ 1.3, ЧДЭМТ 2.2, НДЭМТ 1.8, БНДЭМТ 1.7, СХДНЭ 1.9 хувь байгаа нь Нийслэлийн дундаж үзүүлэлтээс 0.2-1.1 хувиар их байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 2.1 хувьд нь вируст гепатит В, 1.2 хувьд нь вируст гепатит С тус тус илэрсэн байна.

2.1.2 Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь

2023 оны байдлаар улсын хэмжээнд нийт төрсөн эхчүүдийн 80.5 хувь нь жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа үзүүлж хяналтад байж төрсөн бол Улаанбаатар хотод төрсөн эхчүүдийн 80.8 хувь байгаа нь улсын дунджаас 0.3 хувиар, аймгийн дунджаас 0.7 хувиар тус тус өндөр байна.

Жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, дүүргээр /2022-2023/



2.2. ТӨРӨЛТ, ТӨРӨХ ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ


Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих төрөөс баримталж буй бодлого салбарын тэргүүлэх чиглэл байсаар байгаа бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө баталсан А/760 тушаалын хэрэгжилтийн хүрээнд тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар эх, хүүхдийн өвчлөл энэдэгдлийг тогтвортой зорилт тавин олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд төрөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ сайжирсаар байна.

2023 онд Улсын хэмжээнд 63915 эх амаржсан нь өмнөх онтой харьцуулахад 1183 тохиолдлоор буюу 2.0 хувиар, Улаанбаатар хотод 34044 эх амаржиж өмнөх онтой харьцуулахад төрөлт 823 тохиолдлоор буюу 2.3 хувиар тус тус буурсан байна.

2023 онд Улаанбаатар хотод хөдөө, орон нутгаас 5969 эх ирж амаржсан нь нийт төрөлтийн 17.5 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 90 тохиолдлоор буюу 1.5 хувиар байна.


Нийт төрөлтийн 24.6 хувь нь Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, 20.6 хувь нь Нийслэлийн өргөө амаржих газар, 19.0 хувь нь Нийслэлийн амгалан амаржих газар, 16.5 хувь нь Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв, 9.5 хувь нь Нийслэлийн хүрээ амаржих газар, 6.1 хувь нь хувийн эмнэлгүүд, 3.6 хувь нь Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвд байна.

Улаанбаатар хотод хөдөө, орон нутгаас ирж төрсөн эхчүүд, бодит тоо, 2022-2023 он



ДЭМБ-ын зөвлөснөөр нийт төрөлтийн 15 хүртэлх хувь нь мэс заслын аргаар төрүүлж болно гэж зөвлөдөг. Улаанбаатар хотын хувьд 31.3 хувь нь мэс заслаар хүүхдээ төрүүлсэн байгаа нь өмнөх оноос 0.9 хувиар их, улсын дунджаас 3.4 хувиар, аймгийн дунджаас 7.4 хувиар их байна.

Нийт төрөлтөд мэс заслын аргаар төрүүлсэн төрөлтийн эзлэх хувь, эрүүл мэндийн байгууллагаар, 2022-2023 он




НЭМГ-ын харьяа Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар, Багануур, Налайх, Багахангай ЭМТ, Жаргалант ТЭМТ болон “Таны төлөө бид” хувийн эмнэлэгт 18127 төрөлт буюу нийт төрөлтийн 53.2 хувь нь, ЭМЯ-ны харьяа ЭХЭМҮТ, ЭНЭҮТ, ХӨСҮТ, Интермед, Гурван гал хувийн эмнэлэгт 15917

төрөлт буюу 46.8 хувь нь төрсөн байна.

НЭМГ-ын харьяа ЭМБ-д төрсөн эхчүүдээс анхны төрөлт 22.4 хувь, 1 жилийн зайтай төрсөн эх 7.3 хувь, 2 жилийн зайтай төрсөн эх 14.9 хувь, 3 ба түүнээс дээш жилийн зайтай төрсөн эх 55.4 хувь байна. Нийт төрөлтөд 35-аас дээш насны төрөлт 26.6 хувь, 20 хүртэлх насны төрөлт 3.1 хувийг эзэлж байна.

Төрөлтийг насны ангиллаар авч үзэхэд 20 хүртэлх насны төрөлт 3.5 хувь, 20-24 насны төрөлт 20.2 хувь, 25-29 насны төрөлт 27.7 хувь, 30-34 насны төрөлт 27.8 хувь, 35-39 насны төрөлт 16.3 хувь, 40-44 насны төрөлт 4.1 хувь, 45-55 насны төрөлт 0.2 хувийг эзэлж байна. Амаржсан эхчүүдийн 22.4 хувь нь анхны төрөгч, 75.9 хувь нь 2-5 удаа төрсөн, 1.7 хувь нь 6 ба түүнээс дээш удаа төрсөн байна. Улаанбаатар хотод төрсөн эх, насны ангиллаар, 2023 он



Нийт төрөлтийн 99.7 хувийг эх барих, эмэгтэйчүүдийн эмч, 0.2 хувийг их эмч, 0.1 хувийг мэргэжлийн бус хүн удирдаж төрүүлсэн байна. Төрөлтийн тусгай коэффициентийг тооцоход нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутмын 82.8 нь хүүхэд төрүүлсэн байна. Энэ нь 2022 онтой харьцуулахад 5.5-аар буурсан байна.

Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, 2023 он

Насны бүлэг	Тухайн насны эмэгтэйчүүдийн тоо	Тухайн насны эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоо	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент
10-14	83987	16	0.2
15-19	53090	1003	18.9
20-24	45350	6276	138.4
25-29	54549	8601	157.7
30-34	74321	9779	131.6
35-39	76089	6825	89.7
40-44	58976	1696	28.8
45-49	51995	92	1.8
50-54	43983	10	0.2

Энэ үзүүлэлт нь эмэгтэйчүүдийн насны бүлгүүд дэх төрөлтийн ялгавартай түвшнийг илэрхийлнэ. Насны бүлэг дотор 20-24 насны 1000 эмэгтэй тутмын 138.4 нь, 25-29 насны 1000 эмэгтэй тутмын 157.7 нь, 30-34 насны 1000 эмэгтэй тутмын 131.6 нь хүүхэд төрүүлсэн нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Төрөлтийн нийлбэр коэффициентийг насны бүлэг дэх төрөлтийн коэффициентийг ашиглан тооцоход 2.8 байгаа нь нэг эмэгтэй нийт амьдралынхаа туршид дунджаар 3 хүүхэд төрүүлж буйг илэрхийлж байна.

2.2.1 Гэрийн төрөлт

Гэрийн төрөлтийн 121 тохиолдол бүртгэгдсэн нь нийт төрөлтийн 0,36 хувийг эзэлж, байгаа ба өмнөх оны үзүүлэлтээс тохиолдлоор буюу 0.2 хувиар өссөн. Гэрийн төрөлтийн нийт тохиолдлын 38.0 хувь

нь хөдөө орон нутгийн, 62.0 хувь нь УБ хотын харьяалалтай иргэд эзэлж байна.

Төрөлтийн тоо эрүүл мэндийн байгууллагаар, 2023 он


№	Эмнэлгийн нэр	Нийт төрөлт	Гэрийн төрөлт	Хөдөө, орон нутгаас ирж төрсөн эхчүүд	Мэс заслын аргаар төрүүлсэн тоо	Мэс заслын аргаар төрүүлсэн хувь	Эмнэлгийн мэргэжилтэн эх барьсан хувь
1	Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн төв	1240	2	126	362	29.2	100.0
2	Халдварт өвчин судлалын үндэсний төв	5		1	1	20.0	100.0
3	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	8362	52	4544	2431	29.1	99.9
4	Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв	5630	8	466	1753	31.1	99.9
5	Хувийн эмнэлгүүд	2066		107	785	38.0	100.0
6	Өргөө амаржих газар	7030	20	293	2573	36.6	100.0
7	Хүрээ амаржих газар	3249	14	96	1091	33.6	100.0
8	Амгалан амаржих газар	6462	25	336	1676	25.9	99.8
	Бүгд /Total	34044	121	5969	10672	31.3	99.9

Мэдээллийн эх сурвалж: 2023 оны төрөлтийн бааз мэдээлэл

2.2.2 Хяналтгүй төрөлт

Улаанбаатар хотод 2022 онд эмчийн хяналтгүй төрөлтийн 202 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 74 тохиолдлоор өссөн байна. Нийт төрөлтөд эзлэх хувь 0.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2-р өссөн байна. Хяналтгүй төрөлт Баянзүрх, Налайх, Багахангай дүүрэгт нийслэлийн дунджаас өндөр, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд нийслэлийн дундажтай адил байна.


Хяналтгүй төрөлтийн хувь, дүүргээр, 2022-2023



2.2.3 Амьгүй төрөлт

Амьгүй төрөлтийн 211 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор нэмэгдсэн байна. Амьгүй төрөлтийн 26.2 хувь нь хөдөө орон нутгийн, 73.8 хувь нь УБ хотын харьяалалтай иргэд эзэлж байна.

Амьгүй төрөлт, 1000 нийт төрөлтөд, дүүргээр, 2022-2023 он




Амьгүй төрөлт Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Багахангай дүүрэгт хотын дунджаас өндөр байна.

2.3 ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

2023 оны байдлаар Улсын хэмжээнд эмчийн эмнэлгийн хяналтад байж төрсөн эхчүүдээс 89.8 хувь нь төрсний дараа 42 хоногтойдоо идэвхтэй хяналтад хамрагдсан байна. Энэ нь өмнөх оноос 3.5 хувиар өссөн байна.

2023 оны байдлаар Улсын хэмжээнд жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл 48396 бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 752 ногдож байгаа ба өмнөх оноос 5045 тохиолдол буюу 11.6 хувиар өссөн байна.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа амаржих газар, дүүргийн эрүүл мэндийн төв, хувийн эмнэлгүүдэд жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн нийт 13628 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оноос 1829-өөр буурсан ба нийт УБ хотод бүртгэгдсэн хүндрэлийн 49.4 хувийг эзэлж байна. Жирэмсэн, төрөх, төрсний дараах хүндрэлийн 13628 тохиолдол буюу 98.8 хувь нь амаржих газруудад, 205 тохиолдол буюу 1.5 хувь нь Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн төвд бүртгэгдсэн байна.



Жирэмсэн үеийн хүндрэл өмнөх оноос 9.0 хувиар өссөн ба жирэмсэн үеийн хүндрэл манас таталтын урьтал 13.0, манас таталт 0.04 хувь, ихэс түрүүлэлт 0.2 хувь, ихэс цагаасаа өмнө ховхрох 0.3 хувь, жирэмсэн үеийн бөөр шээсний замын халдвар 2.1 хувь, ураг орчмын шингэн багасалт 15.1 хувь, бусад 6938 хувийг эзэлж байна.

Төрөх үеийн хүндрэл өмнөх оноос 5.4 хувиар буурсан ба ус эрт гарах 39.6 хувь, төрөх хүчний сулралт 43.7 хувь, ургийн буруу байрлалаас төрөлт саатах 3.3 хувь, эхийн аарцаг ясны хөгжлийн гажгаас төрөлт саатах 1.7 хувь, хязангийн урагдалт 3.2 хувь, умайн хүзүүний урагдал 0.4 хувь, бусад 8.1 хувийг эзэлж байна.

Төрсний дараах хүндрэл өмнөх оноос 0.1 хувиар буурсан ба төрсний дараах эрт үеийн /4цаг/ цус алдалт 77.6 хувийг, хожуу цус алдалт 0.3 хувийг, төрсний дараах 3-р үеийн цус алдалт 3.8 хувь, төрсний дараах халдвар 12.6 хувийг тус тус эзэлж байна.

Нийт хүндрэлийн дотор 5.7 хувийг жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл эзэлж байгаа ба өмнөх оноос 2.1 хувиар өссөн байна.

2.4 ЭХИЙН ЭНДЭГДЭЛ

Тогтвортой хөгжлийн зорилтод 2030 онд 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшнийг 70 болгох зорилт тавьсан Монгол Улсын хувьд “Алсын хараа 2050” Монгол Урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлсноор 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшнийг 2025 онд 20.0, 2030 онд 5.0 болгох зорилт тавьсан.


Улсын хэмжээнд 2023 оны байдлаар эхийн эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдсэнээс 13 тохиолдол нь Улаанбаатар хотод бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 37.9 болсон нь улсын дунджаас 11.5-аар их үзүүлэлттэй байна. Эхийн эндэгдлийн 13 тохиолдол УБ хотын харьяалалтай байгааг дүүргээр авч үзвэл Баянгол 1, Баянзүрх 3, Сонгинохайрхан 1, Хан-Уул 1, Хөдөө орон нутгийн 7 тус бүртгэгдсэн байна.

100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл Баянгол, Хан-Уул дүүрэгт Улаанбаатар хотын дунджаас 21.2-33.5-р өндөр байна. Эхийн эндэгдэл Сүхбаатар, Чингэлтэй, Налайх, Багануур, Багахангай дүүрэгт бүртгэгдээгүй байна.

Эхийн эндэгдлийн түвшин, 100 000 амьд төрөлтөд, 2014-2023 он


Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Эхийн эндэгдэл/ бодит тоо										
Улс	25	21	38	20	21	18	19	68	23	17
Улаанбаатар	15	12	17	12	12	10	11	43	10	13
Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлтөд										
Улс	30.6	26	48.6	26.9	27.1	23	30.2	94.9	35.1	26.4
Улаанбаатар	35.9	28.8	41.8	31.2	29.5	24.3	27.7	118.1	28.4	37.9

Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, 2014-2023 он



Улаанбаатар хотод бүртгэгдсэн эхийн эндэгдлийн 13 тохиолдлоос 7 тохиолдол буюу 53.8 хувийг ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, 6 нь нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 2 дүүргийн эрүүл мэндийн төв, 4 амаржих газраас мэдээлсэн ба эндсэн газраар нь авч үзвэл 12 эх нь эмнэлэгт, 1 эх бусад газарт эндсэн байна.


Эхийн эндэгдэл, бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагаар




Эндсэн эхчүүдийг насны ангиллаар авч үзвэл:

30.8 хувь нь 20-24 нас, 38.5 хувь нь 30-34 нас, 15.4 хувь нь 35-39, 15.4 хувь 40-45 насны эмэгтэйчүүд эзэлж байна.

Эндсэн эхчүүд насны ангиллаар, 2023 он



Эхийн эндэгдлийн шалтгаан, 2023 он



Эндсэн эхчүүдийн 4 буюу 30.8 хувь нь эх барихын шууд шалтгаантай, 9 буюу 69.2 хувь нь эх барихын шууд бус шалтгаантай эндэгдэл байна.


2.5 ЖИРЭМСЛЭЛТЭЭС СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН АРГА, ХЭРЭГЛЭЭ

Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслэлийг зөв хэрэглэх нь хэт эрт, хэт орой жирэмслэхээс сэргийлэх, төрөлт хоорондын зайг зохицуулах, нийт хүүхдийн тоог хязгаарлах зэрэг боломжийг олгодог ач холбогдолтой. .


Жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэгслийг орчин үеийн болон уламжлалт гэж ангилдаг ба орчин үеийн аргад умайн гуурсан хоолой, эрэгтэй үрийн суваг боох, ерөндөг, тариа, суулгац, эм, эрэгтэй/эмэгтэй бэлгэвч, диафрагм, лаа, царцмаг болон яаралтай ууж хамгаалах эмийн аргууд хамаардаг.

2023 оны байдлаар төрөх насны эмэгтэйчүүдийн 48.4 хувь нь ЖСА хэрэглэдэг гэсэн статистик үзүүлэлт байгаа нь өмнөх оноос 1.5 хувиар өссөн байна. Нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйчүүдийн 484 нь ямар нэг жирэмслэлтээс сэргийлэх аргыг хэрэглэдэг байна.

Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглээ, хувиар



Жирэмслэлтээс сэргийлэх арга, 2022 он



2.6 ҮР ХӨНДӨЛТ

Жирэмсэлсний дараа үр хүүхэдтэй болохыг хүсэхгүй байх нь үр хөндүүлэх үндсэн шалтгаан болдог. Хүсээгүй байхдаа жирэмсэн болох шалтгаан нь жирэмслэлтээс хамгаалах аргуудыг хэрэглэлгүйгээр бэлгийн харьцаанд орох мөн хэрэглэсэн боловч зөв хэрэглэж чадаагүйтэй холбоотой. Хөгжиж буй орнуудад хүсээгүй жирэмслэлтийн 84 хувийг орчин үеийн жирэмснээс сэргийлэх арга, хрэгслийн хангагдаагүй хэрэгцээтэй эмэгтэйчүүд эзэлдэг. Үр хөндөлтийн хувь хэмжээ нь гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөрүүдийн үр ашгийг харуулах чухал үзүүлэлт болдог.

Улсын хэмжээнд 2023 онд 12197 үр хөндөлтийн тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 189.7, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 14.6 үр хөндөлт ногдож байна. Өмнөх оноос 871 тохиолдлоор буюу 6.6 хувиар, 1000 амьд төрөлтөд 9.5 тохиолдлоор тус тус буурсан байна.

Улаанбаатар хотын эмнэлэгт үр хөндөлтийн 9168 тохиолдол бүртгэгдсэн нь нийт үр хөндөлтийн 75.2 хувийг эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд 267.3, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутмын 22.1 нь үр хөндүүлсэн нь өмнөх оноос 480 тохиолдол буюу нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутамд 2.4-өөр тус тус буурсан байна.


Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа улсын болон хувийн эмнэлэгт 6824 тохиолдол буюу 74.4 хувь нь, ЭМЯ-ны харьяа ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-д 2112 тохиолдол буюу 23.0 хувь, хувийн эмнэлэгт 232 тохиолдол буюу 2.5 хувь нь үр хөндүүлсэн байна.

Үр хөндөлт бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагаар, 2019-2023 он

Эрүүл мэндийн байгууллага	2019		2020		2021		2022		2023	
	Нийт бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь	Нийт бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь	Нийт бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь	Нийт бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь	Нийт бүртгэгдсэн үр хөндөлтийн тоо	20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь
ЭХЭМҮТ	1748	8.6	1556	6.9	1361	6.4	1487	9.0	1448	10.6
ЭНЭҮТ					8	0.0	372	2.9	664	5.1
Амаржих газар	7284	4.5	6772	3.8	5375	3.3	5808	3.7	3407	5.2
Дүүргийн ЭМТ	89	9.0	83	4.8	106	1.9	86	10.4	90	12.2
Хувийн эмнэлэг	2076	2.1	2005	2.0	1509	2.0	1895	2.0	1797	3.1
Бүгд	11197	4.7	10416	3.8	8359	3.6	9648	4.2	9168	4.6

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үр хөндөлт 480 тохиолдлоор буурсан байна. (ЭХЭМҮТ-39, Амаржих газар-2401, Хувийн эмнэлэг-98)

Үр хөндөлт, 1000 амьд төрөлтөд, 2014-2023 он



Үр хөндөлт 1000 амьд төрөлтөд аймгийн дунджаас 166.4-өөр, улсын дунджаас 79.6-аар тус тус өндөр байна. НЭМГ-ын харьяа эмнэлэгт үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 2.9 хувь нь хожуу үр хөндүүлсэн ба өмнөх оноос 1.6 хувиар буурсан байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 17.9 хувь нь төрөөгүй эмэгтэйчүүд эзэлж байна. 20-оос доош насны үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн хувь 3.4 байгаа нь өмнөх оноос 0.5-аар нэмэгдэж, улсын дунджаас 1.6 хувиар бага үзүүлэлттэй байна.

Үр хөндөлтийн 1 хүндрэлийн тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой адил ба умайн агшилт суларч цус алдсан хүндрэл байна.

2.7. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

2023 оны байдлаар улсын хэмжээнд 64306 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 1280 хүүхдээр буюу 2.0 хувиар буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 4.4 хувь нь 2500 граммас доош жинтэй төрсөн. Амьд төрсөн хүүхдийн 1428 хоёр ихэр, 12 нь гурван ихэр хүүхэд байна.

Улаанбаатар хотод нийт 34243 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оноос 954 хүүхдээр хасагдсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 53.3 хувь буюу 18224 хүүхэд НЭМГ-ын харьяа амаржих газар болон хувийн эмнэлэгт төрсөн ба 51.5 хувь нь хүү, 48,5 хувь нь охин байна.

Төрөөд 1 цагийн дотор хөхөө амалсан хувь 95.6 байгаа нь өнгөрсөн оноос 0.3-аар өссөн

байна. Амьд төрсөн хүүхдийн 5.0 хувь нь 2500 граммас бага жинтэй төрж, 99.6 хувь нь БЦЖ, 99.7 хувь нь саагийн, 99.6 хувь нь гепатитын вакцин хийлгэсэн байна.

Амьд төрсөн нярайн 896 нь 2 ихэр, 12 нь гурван ихэр, 7.9 хувь нь дутуу, 0.4 хувь нь бүтэлтэй төрсний 80.0 хувь нь амьдарч, 20.0 хувь нь нас барсан байна. Амьд төрсөн нярайн 0.8 хувьд нь төрөлхийн гажигтай нярай бүртгэгдсэн байна.

Амьд төрсөн хүүхэд, бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллагаар, 2023 он

Эрүүл мэндийн байгууллагууд	Төрсөн хүүхэд					Амьгүй төрөлтийн түвшин (нийт 1000 төрөлтөд)
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа (100-д)	Бага жинтэй хүүхдийн эзлэх хувь	
Амаржих газар	16827	8632	8195	105.3	4.0	5.2
Эрүүл мэндийн төв	1250	668	582	114.8	3.4	3.2
Хувийн эмнэлэг	2085	1085	1000	108.5	1.7	1.0
НЭМГ-ын дүн	18224	9377	8847	106.0	4.0	5.0
Улаанбаатар	34298	17711	16587	106.8	5.0	6.1
Аймгийн дүн	30008	15353	14655	104.8	3.6	4.4
Улсын дүн	64306	33064	31242	105.9	4.4	5.3

Улаанбаатар хотод нярай хүүхдийн өвчлөлийн 16776 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх оноос 1951-ээр нэмэгдэж, давхардсан тоогоор амьд төрсөн хүүхдийн 48.9 хувь нь өвчилсөн бол НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд 4267 буюу 25.4 хувь нь бүртгэгдэж, амьд төрсөн хүүхдийн 23.4 хувь нь өвчилсөн байна. Нярай хүүхдийн өвчлөлийн аймгийн дундаж /47.2/, улсын дундаж /48.1/ байна.

Улаанбаатар хотын нярайн өвчлөлд перинаталь үед үүссэн эмгэг 84.2 хувийг эзэлж байгаа бол НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд 86.1 байна. Үүнээс: нярайн шарлалт 41.0 хувь, Нярайн ишемийн шалтгаант энцефалопати 24.1 хувь, перинаталь өвөрмөц бусад халдвар 7.5 хувь, нярайн амьсгал гачаал 3.3 хувийг тус тус эзэлж тэргүүлэх шалтгаан болж байна.

Төрөлхийн гажгийн 276 459 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх оноос 183 тохиолдол буюу 39.9 хувиар буурсан байна.

Нярай хүүхдийн өвчлөл, 2023 он

Үзүүлэлт	Нийт өвчлөл		Перинаталь үед үүссэн зарим эмгэг		Халдварт ба шимэгчит өвчин		Амьсгалын тогтолцооны өвчин		Хоол шингээх эрхтэний эмгэг		Гэмтэл хордлого ба гадны шалтгаант эмгэг		Бусад өвчлөл
					Бүгд	Үүнээс: Төрөлхийн тэмбүү	Бүгд	Үүнээс: Уушгины хатгаа	Бүгд	Үүнээс: Халдварт бус суулгалт			
Аймгийн дүн	14153	10824	18	4	1618	558	224	8	7	1462			
Улаанбаатар	16760	14247	25	16	436	93	139	8	23	1890			
Улсын дүн	30913	25071	43	20	2054	651	363	96	30	3352			


2.8. НЯЛХАС БОЛОН ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

Хүүхдийн эндэгдэл сүүлийн жилүүдэд тогтвортой буурч байгаа нь хөхөөр хооллолт, өргөн дархлаажуулалт, хүүхдийн өвчний цогц менежмент зэрэг нийгмийн эрүүл мэндийн оновчтой арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлж байгаатай шууд холбоотой юм.


Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд, сүүлийн 10 жилээр

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	17.8	17.3	18.2	15.4	16.1	14.9	13.4	13.1	15.0	15.7
Нялхсын эндэгдлийн түвшин	14.9	14.7	15.0	12.7	13.6	12.9	11.8	11.1	12.5	13.7

Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрсөн хүүхдэд



Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрсөн хүүхдэд, 2014-2023 он



2023 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд нялхсын эндэгдлийн 469 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 30 тохиолдлоор буюу 6.8 хувиар, амьд төрсөн 1000 хүүхдэд 13.7 болж 1.2 промилиор өссөн байна. Нялхсын эндэгдлийн 22.3 хувь нь НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд, 77.7 хувь нь ЭМЯ-ны харьяа эмнэлгүүдэд эндсэн байна. Нялхсын эндэгдэл Налайх дүүрэгт Улаанбаатар хотын дунджаас 5.3-аар өндөр байна.

Нялхсын эндэгдлийн 61.8 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 8.5 байна. Нярайн эндэгдэлийн нийт 290 тохиолдол бүртгэгдсэнээс 200 буюу 69.0 хувь нь нярайн эрт үед (амьдралын 0-6 хоногт), 90 буюу 31.0 хувь нь нярайн хожуу үед (амьдралын эхний 7-28 хоногт) эндсэн байна.

НЭМГ-ын харьяа эмнэлгүүдэд бүртгэгдсэн нялхсын эндэгдлийн 79.3 хувь нь эрт үед, 20.7 хувь нь нярайн хожуу үед, 16.3 хувь нь 29-365 хүртэлх хоногтойдоо эндсэн байна.

Улсын хэмжээнд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 961 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 537 тохиолдол буюу 55.9 хувь нь бүртгэгдсэн байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг тогтмол хаягаар авч үзэхэд УБ хотын харьяаллын тав хүртэлх насны хүүхдийн нас баралт 354 367 болж өмнөх оноос 13 тохиолдлоор буурсан байна.

Улаанбаатар хотод бүртгэгдсэн нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 469 тохиолдлын 307 нь буюу 69.2 хувь нь УБ хотын харьяаллын хүүхдүүд эндсэн байна. УБ хотод эндсэн нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл дотор хөдөө орон нутгийн харьяалалтай 162 хүүхэд эндсэн байна.

Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл перинаталь үед үүссэн эмгэг өвчлөлийн хамааралтай нас баралт тэргүүлэх шалтгаан болсоор байна. НЭМГ-ийн харъяа эмнэлэгт Нярайн эрт үеийн перинаталь үед үүссэн эмгэгийн нас баралтад нярайн амьсгалын гачаал 32.7 хувийг, нярайн ишемийн шалтгаант энцефалопати 23.5 хувийг, төрөх үеийн бүтэлт 12.2 хувийг, төрөлхийн гажиг 4.1 хувийг эзэлж байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд амьсгалын тогтолцооны өвчлөлөөс шалтгаалсан эндэгдэл дотор уушгины хатгаагаар 71.4 хувь, төрөлхийн гажгаас 40.0 хувийг зүрх судасны тогтолцооны гажиг, 20.0 хувийг дауны хам шинж, 40.0 хувийг бусад эрхтэн тогтолцооны төрөлхийн гажиг тус тус эзэлж байна.

Улаанбаатар хотод тав хүртэлх насны хүүхдийн бэртэл, хордлого, осол гэмтлийн гаднын шалтгаант нас баралтын 42 тохиолдол бүртгэгдсэн ба 26 буюу 61.9 хувь нь УБ хотын харьяаллын хүүхэд эндсэн нь өмнөх оноос 17 тохиолдлоор өссөн бөгөөд НЭМГ-ийн харъяа эмнэлэгт 5 тохиолдол бүртгэгдсэн.

Улаанбаатар хотод 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 19 буюу 4.1 хувь, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 23 буюу 33.8 хувийг осол гэмтлийн шалтгаант эндэгдэл эзэлж байна.

Осол гэмтлийн шалтгаант эндэгдлийг хэлбэрээр авч үзвэл 85.7 хувийг гадны шалтгаант бусад осол, 0.6 хувийг зам тэврийн осол эзэлж байна. Гадны шалтгаант бусад ослоор эндсэн эндэгдлийн дотор орон дотроо санамсаргүй амьсгал боогдох 11.9 хувь, хоол болон гадны биет залгих буюу амьсгалснаас амьсгалын зам бөглөрөх 14.3 хувь, барилга байгууламжаас ойчих 14.3 хувийг эзэлж байна.

Шалтгаан	1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	
	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	278	59.3	278	51.8
Төрөлхийн гажиг, гаж хөгжил	104	22.2	113	21.0
Амьсгалын тогтолцооны өвчин	24	5.1	32	6.0
Гадны шалтгаант өвчлөл ба нас баралт	19	4.1	42	7.8
Халдварт өвчин	7	1.5	10	1.9
Мэдрэлийн тогтолцооны өвчин	4	0.9	13	2.4
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	3	0.6	6	1.1
Хавдар	11	2.3	20	3.7
Бусад	19	4.1	23	4.3
Нийт/Total	469	100.0	537	100.0


Тэргүүлэх шалтгаан
 Хоёрдугаар шалтгаан
 Гуравдугаар шалтгаан

Улсын хэмжээнд 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 168 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 68 тохиолдол буюу 40.5 хувь нь, 100 тохиолдол буюу 59.5 хувь нь хөдөө орон нутгаас бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотод 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 68 тохиолдол бүртгэгдсэний 69.1 хувь буюу 47 тохиолдол нь Улаанбаатар хотын харьяат, 30.9 хувь буюу 21 тохиолдол нь хөдөө орон нутгаас ирж энджээ.


Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгааныг өмнөх онтой харьцуулахад төрөх тойрны перинаталь үеийн эмгэг 5.7%-иар, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчний шалтгаант 4.5 %-

иар, гадны шалтгаант нас баралт 2.7%-иар, хавдрын шалтгаант 2.0%-иар тус тус өссөн бол төрөлх гажиг, гаж хөгжил 4.1%-иар, мэдрэлийн тогтолцооны шалтгаант 1.5%-иар, хоол боловсруулах тогтолцооны шалтгаант 1.0%-иар, бусад шалтгаан 7.4 хувиар тус тус буурсан байна.

Нялхсын эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, хувиар, 2019-2023 он



Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан, хувиар, 2019-2023 он




1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 68 тохиолдол бүртгэгдсэн нь амьд төрсөн 1000 хүүхдэд харьцуулахад 2.0 болж өмнөх оноос 0.5 промилиор буурсан байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр:

НЭМГ-ын даргын 2020 оны “Хүүхдийн эндэгдэлд авах зарим арга хэмжээний тухай” А/32 дугаар тушаалын дагуу хүүхдийн эмнэлгийн бус эндэгдлийн тохиолдолд Эмгэг судлалын үндэсний төвийн эмгэг судлалын тусламж, үйлчилгээний албаар шинжилгээг хийлгэн, дүгнэлт гармагц эмнэлзүй-эмгэг судлалын конференцийг тогтмол зохион байгуулан, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах, алдаанаас суралцах, дахин давтагдах эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөл байгуулан, улирал бүрээр төлөвлөгөө гарган үр дүнг тооцон ажиллаж хэвшсэн.

Дээрх тушаал хэрэгжиж эхэлсэн сүүлийн 3 жилд хүүхдийн сэргийлж болох эндэгдэл, үүнээс эмнэлгийн бус эндэгдэл нийслэлийн хэмжээнд тогтвортой буурсаар байгаа нь бидний гол амжилт юм. Тухайлбал, 2019 онд 92, 2020 онд 71, 2021 онд 66, 2022 онд 75, 2026 онд 68 тохиолдол бүртгэгдээд байгаа бөгөөд 2019 оноос 24 тохиолдол буюу 0.5 промилээр буурсан байна.

5-19 насны хүүхдийн эндэгдэл бодит тоо, дүүргээр, 2019-2023 он



Өсвөр насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаанд сүүлийн жилүүдэд бэртэл хордлого, гадны шалтгаант өвчлөл, эндэгдэл тэргүүлэх байранд орсоор байна.

10-14 насны 10000 хүүхэд тутмын 1.1 нь осол гэмтлээр эндсэн нь өмнөх оноос 0.1-ээр, 5-19 насны 10000 хүүхэд тутмын 1.5 нь эндсэн нь өмнөх оноос 3.9-өөр буурсан байна. Өсвөр үеийнхний дотор амиа хорлох, бусад осол, зам тээврийн ослоор дийлэнх нь нас барсан нь тулгамдсан асуудлын нэг хэвээр байсаар байна.

Өсвөр үеийнхний гадны шалтгаант эндэгдлийг тэргүүлэх шалтгаан, хувиар, 2019-2023

Нас барсан хэлбэр	2019		2020		2021		2022		2023	
	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь
Амиа хорлосон	9	17.0	13	16.7	15	15.5	14	20.0	12	16.4
Хий уурын хордлого	6	11.3	21	26.9	18	18.6	11	15.7	22	30.1
Барилга байгууламжаас ойчих	14	26.4	10	12.8	16	16.5	20	28.6	15	20.5
Зам тээврийн осол	8	15.1	5	6.4	11	11.3	3	4.3	11	15.1
Бусад осол	16	30.2	28	35.9	37	38.1	20	28.6	13	17.8
Тодорхой бус	0	0.0	1	1.3	0	0.0	0	0.0	0	0
Үйлдвэрийн осол	0	0.0	0	0.0	0	0.0	2	2.9	0	0
Нийт/Total	35	100.0	48	100.0	64	100.0	41	100.0	73	100.0

БҮЛЭГ III. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээ гэж өвчин эмгэг, гэмтэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг”, “Эмнэлэг гэж эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий хуулийн этгээд (эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, 3 дугаар зүйл) юм.

Монгол Улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эм хангамж, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн болон хувийн хэвшил, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ. “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ” гэж өвчин эмгэг, гэмтэл бэртэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг хэлнэ гэж “Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай” хуулинд заасан.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь төрийн онцгой ивээлд нэгдсэн зохицуулалттай байж, тусламж үйлчилгээг үзүүлэхдээ төр, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг харилцан ашигтай, шударга, үйлчлүүлэгчээ дээдэлсэн тэгш хүртээмжтэй байхад чиглэнэ. Энэхүү бүлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээний албан ёсны статистик мэдээллийг Эрүүл мэндийн байгууллагуудын шатлал тус бүрээр харьцуулан дүгнэлээ.

Эрүүл мэндийн байгууллага, анхан болон лавлагаа шатлалаар, 2023 он

№	Эрүүл мэндийн байгууллага		Аймгийн дүн	Улаанбаатарын дүн	Улс
1	Өрхийн эрүүл мэндийн төв		76		224
2	Тосгоны эрүүл мэндийн төв		16		20
3	Сумын эрүүл мэндийн төв	А зэрэглэл	53		53
4		Б зэрэглэл	113		113
5		В зэрэглэл	141		141
6	Сум нэгдсэн эмнэлэг		6		6
7	Аймгийн нэгдсэн эмнэлэг		16		16
8	Дүүргийн нэгдсэн эмнэлэг				4
9	Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, НЭМҮТ				10
10	Бүсийн оношилгоо эмчилгээний төв		5		5
11	Тусгай мэргэжлийн төв				3
12	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг		1		14
13	Амаржих газар				3
14	Түргэн тусламжийн төв				1
15	Клиник (хувийн)		494	972	1466
16	Ортой эмнэлэг		102	114	216
17	Сувилал		52	45	97
18	Эм ханган нийлүүлэх байгууллага		79	49	128
19	Эмийн сан		955	1142	2097
20	Тусгай эмнэлэг		23	6	29
21	Бусад		74	26	100
	Нийт		2206	2540	4746

2023 онд статистик тайлан ирүүлсэн 4746 эрүүл мэндийн байгууллагаас хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 14, тусгай мэргэжлийн төв 3, бүсийн оношилогоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг 4, дүүргийн эрүүл мэндийн төв 10, сумын нэгдсэн эмнэлэг 6, сумын эрүүл мэндийн төв 307, өрхийн эрүүл мэндийн төв 224, ортой хувийн эмнэлэг 216, хувийн клиник 1466 байна.

3.1. АМБУЛАТОРИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ


Улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 23164288 амбулаторийн үзлэг хийгдсэний 25.1 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 59.8 хувийг өвчний учир амбулаторит, 5.9 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 9.2 хувийг гэрийн үзлэг тус тус эзэлж байна. Үүнээс Улаанбаатарт 14298637 үзлэг буюу 61.7 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 13.5 хувиар буюу 1925144 үзлэгээр өссөн байна. Нийт үзлэгийн 30.4 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвд хийгдсэн байна.

Улсын хэмжээнд нэг эмчид ногдох хүний тоо 225.8 байгаа бол Улаанбаатарын хэмжээнд энэ үзүүлэлт 164.2 байна. Нэг эмчид ногдож байгаа үзлэгийн тоо улсын хэмжээнд 1546.0, Улаанбаатарын хэмжээнд 1451.0 байгаа бол нийслэлд 1547.6 байна.


Улсын хэмжээнд нэг сувилагчид ногдох хүний тоо 233.0 байгаа бол Улаанбаатарын хэмжээнд энэ үзүүлэлт 205.0 байна.

Улаанбаатарт нийт үзлэгийн 30.4 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвд хийгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Амбулаторийн нийт үзлэгийн 23.1 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 53.1 хувийг өвчний учир амбулатори, 5.8 хувийг диспансерийн хяналтын үзлэг, 11.7 хувийг гэрийн идэвхтэй хяналтын үзлэг, 0.4 хувийг гэрийн дуудлага тус тус эзэлж байна.

Нийт үзлэг, эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрлөөр, хувиар, 2023 он



Нийт үзлэгийн бүтэц, хувиар, 2023 он



Амбулаторийн тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2014-2023 он

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
----------	------	------	------	------	------	------	------	------	------	------

10000 хүн амд ногдох нийт ажиллагсад	174.9	181.2	178.0	195.3	199.5	208.2	213.6	218.9	236.5	243.0
10000 хүн амд ногдох их эмч	42.4	42.3	42.2	45.9	48.2	49.9	52.4	54.2	58.1	60.9
Жилд нэг иргэний үзүүлсэн дундаж тоо	6.4	6.4	6.4	7.4	7.3	7.7	6.8	6.0	8.0	9.0
Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	29.9	29.4	30.7	30.1	28.6	36.0	32.1	31.0	29.1	23.1
Нэг их эмчид ногдох хүний тоо	236.1	236.5	236.9	217.6	207.5	200.6	191.0	181.0	172.0	164.2

Мэс заслын хагалгаа, Улаанбаатар хот, 2023 он

Эрүүл мэндийн байгууллага	Мэс засал хийлгэсэн хүний тоо				Үүнээс:	
	Бүгд	0-15 насны	Дурангийн мэс засал	Давтан хагалгаа	Мэс заслын хүндрэл	Нас барсан
Нийслэлийн Эрүүл мэндийн газар	50.7	59.4	23.8	22.4	8.5	5.7
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	9.1	0.1	31.8	26.2	19.1	19.6
Улсын хоёрдугаар төв эмнэлэг	3.1	0.0	11.2	3.0	8.9	9.2
Улсын гуравдугаар төв эмнэлэг	5.7	0.7	1.3	24.0	10.3	0.9
Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	7.5	26.8	1.3	24.0	10.3	0.9
Халдварт өвчин судлалын үндэсний төв	0.4	0.2	0.0	5.5	0.0	0.0
Хавдар судлалын үндэсний төв	2.4	0.0	1.2	7.2	38.8	7.1
Гэмтэл согог судлалын үндэсний төв	8.4	9.1	2.0	3.3	2.6	43.8
Монгол Японы эмнэлэг	1.9	0.6	5.3	0.0	4.0	0.0
Эх нярайн, эмэгтэйчүүдийн үндэсний төв-2	0.4	0.4	0.4	0.0	0.0	0.0
АШУҮИС-ийн төв эмнэлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ЭМЯ-ны харьяа хувийн эмнэлэг	10.5	2.6	21.7	4.1	1.6	2.0
Бүгд	100	100	100	100	100	100

Түргэн тусламжийн үйлчилгээ

Нийслэлийн хүн амд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээг нийслэлийн Түргэн тусламжийн төв, түүний салбарууд, алслагдсан дүүргийн эрүүл мэндийн төв болон тосгодын эрүүл мэндийн төвүүд үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн Сайдын 2019 оны “Журам батлах тухай” А/294 дүгээр тушаалаар батлагдсан “Түргэн тусламжийн үйлчилгээг зохион байгуулах үлгэрчилсэн журам”, “Түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 6717:2018 стандартыг мөрдөн ажиллаж байна.

НЭМГ-аас нийслэлийн хүн амд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, шуурхай, аюулгүй байдлыг хангах, яаралтай дуудлагын 20 минутын очилтын хувийг нэмэгдүүлэх зорилгоор түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулж алслагдсан дүүргийн эрүүл мэндийн төв, тосгодын эрүүл мэндийн төвүүдийг мэргэжил арга зүйгээр хэрхэн хангах талаар тусгах зорилт тавин ажиллаж байна.


Улаанбаатарт 2023 оны байдлаар Нийслэлийн түргэн тусламжийн төв болон дүүрэг, тосгоны ЭМТ-д нийт 446850 дуудлага хүлээн авч үйлчилсэнээс 54469 буюу 12.2 хувийг осол гэмтлийн

дуудлага эзэлж байна. Нийт дуудлага өмнөх оноос 38815-аар, осол гэмтлийн дуудлага 8490-ээр өссөн байна.

№	Дуудлагын төрөл	Бодит тоо	Эзлэх хувь
1	НТТТ /Насанд хүрэгсдийн/	345300	77.3
2	НТТТ /хүүхэд/	101551	22.7
3	Алслагдсан ЭМТ болон тосгодын ЭМТ	23723	5.3
4	Нийт	446850	100

Нийслэлийн түргэн тусламжийн төв 423127 дуудлага хүлээн авч үйлчилснээс 52919 тохиолдол буюу 12.5 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байна. Нийт дуудлагын 21.0 хувь нь хүүхдийн, 79.0 хувь нь насанд хүрэгчдийн дуудлага эзэлж байна. Нийт дуудлагын дотор яаралтай дуудлага 63.5 хувийг үүнээс 20 минутын дотор 74.3 хувьд нь очиж эмнэлгийн тусламж үзүүлсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар өссөн байна.

Дуудлагын төрөл, Улаанбаатар, хувиар, 2019-2023 он



2023 онд нийт дуудлагын 76.8 хувийг гэнэтийн өвчлөлийн, 2.6 хувийг төрөхийн, 12.2 хувийг осол гэмтлийн дуудлага, 8.4 хувийг бусад дуудлага эзэлж байна. Осол гэмтлийн дуудлага өмнөх оноос 0.2 хувиар нэмэгдсэн байна.

Нийт насанд хүрэгсдийн осол гэмтлийн дуудлагын 24.2 хувь нь гудамжны, 6.0 хувь нь зам тээврийн осол, 0.5 хувь нь амиа хорлосон, 4.0 хувь нь бусад хорлогдсон, 2.3 хувь нь үйлдвэрийн осол, 0.6 хувь нь спортын, 41.0 хувь нь архины хордлогын, 21.2 хувийг бусад осол тус тус эзэлж байна.

2023 онд хүүхдийн дуудлагын 2.4 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байна. Үүнээс 20.3 хувийг ахуйн осол гэмтэл, 11.5 хувийг түлэгдэлт, 48.3 хувийг угаарын хийн хордлого, 1.2 хувийг эмийн бодисын хордлого, 0.7 хувийг химийн бодисын хордлого, 1.8 хувийг хоолны хордлого, 7.0 хувийг зам тээврийн осол гэмтэл, 9.3 хувийг бусад осол тус тус эзэлж байна.

3.2 ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

2023 оны байдлаар ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, НЭМГ-ын харьяа болон мэдээ ирүүлдэг эмнэлгүүдэд хийт 583721.0 хүн хэвтэн эмчлэгдэн, 3.895.941 ор хоног ашигласан бөгөөд ор ашиглалтын хувь 75.3, дундаж ор хоног 6.7, орны эргэлт 41.2 байна.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа болон бусад мэдээ ирүүлдэг ор бүхий эмнэлгүүдэд 267.780.5 хүн хэвтэн эмчлэгдэн, 1.654.098 ор хоног ашигласан бөгөөд ор ашиглалтын хувь 71.6, дундаж ор хоног 6.2, орны эргэлт 42.3 байна.

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар эмнэлэгт 1042835 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж 7146999 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 6.9 байна. Улсын дунджаар ор ашиглалтын хувь 66.1, өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэвтэн эмчлүүлэгч 37090 хүнээр, ор хоног 257731-ээр тус тус өссөн байна.


Эмнэлгийн орны үзүүлэлт, 2014-2023 он



Нийт хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөлд Улаанбаатар хотын харьяаллын иргэдийн өвчлөл 74.5 хувийг эзэлж байна. Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа болон бусад мэдээ өгдөг ор бүхий эмнэлгүүдэд 317833.5 хүн хэвтэн эмчлэгдэж, 2041720 ор хоног ашигласан бөгөөд ор ашиглалтын хувь 69.2, дундаж ор хоног 6.4, орны эргэлт 39.3 байна.

2023 онд ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, НЭМГ-ын харьяа болон мэдээ ирүүлдэг эмнэлгүүдэд 8928 нас баралтын тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 301 тохиолдлоор буурсан байна. Нийт нас баралтын 48.5 хувь нь НЭМГ-ын харьяа улс болон хувийн эмнэлэгт, 51.5 хувь нь ЭМЯ-ны харьяа төв эмнэлгүүдэд бүртгэгджээ.

Эмнэлгийн нас баралт, 2014-2024 он



НЭМГ-ын харьяа улс, хувийн хэвшил болон бусад эмнэлэгт нийт 4334 нас баралтын тохиолдол бүртгэгдсэний 53.7 хувь нь эрэгтэй, 46.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Нас баралтыг шалтгаанаар авч үзэхэд хорт хавдрын нас баралт 32.5, сүрьеэгийн нас баралт 0.4, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 3.1 хувийг тус тус эзэлж байна. Коронавирусын халдварын нас

баралтын 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, 2023 он

№	Байгууллага		Орны тоо	Үүнээс: хүүхдийн орны тоо	Эмчлэгдсэн өвчтөн	Фонд ашиглалтын хувь	Эмнэлгийн нас баралт		Дундаж ор хоног	Орны эргэлт
							Бодит тоо	Хувь		
1	Дүүргийн эрүүл мэндийн төв	Баянгол	405	196	14719.5	61.6	190	1.3	6.2	36.3
2		Сонгинохайрхан	298		8756.5	58.0	133	1.5	7.2	29.4
3		Хан-Уул	90		3901.5	90.2	16	0.4	7.6	43.4
4		Чингэлтэй	262	80	9090.0	58.2	102	1.1	6.1	34.7
5		Налайх	215	32	8385.5	74.5	31	0.4	7.0	39.0
6		Багануур	253	44	9368.0	69.6	42	0.4	6.9	37.0
7		Багахангай	35	6	853.0	47.1	1	0.1	7.1	24.4
8	Нэгдсэн эмнэлэг	Баянзүрх	358	130	16897.5	80.5	200	1.2	6.2	47.2
9		Сонгинохайрхан	365	130	21150.5	91.2	225	1.1	5.7	57.9
10		Сүхбаатар	345	120	16457.5	85.2	147	0.9	6.5	47.7
11		Хан-Уул	246	80	16051.5	112.3	28	0.2	6.3	65.3
12	Амаржих газар	Өргөө	363	23	20212.0	82.4	43	0.2	5.4	55.7
13		Хүрээ	85	10	7497.5	102.1	9	0.1	4.2	88.2
14		Амгалан	200	20	14011.0	94.5	27	0.2	6.3	40.5
15	Тосгоны эрүүл мэндийн төв	Гачуурт	17	2	189.5	22.0	0	0.0	7.2	11.1
16		Жаргалант	15	2	452.0	56.0	1	0.2	6.8	30.1
17		Туул	15	5	653.5	82.2	0	0.0	6.9	43.6
18		Хонхор	15	6	451.0	55.7	0	0.0	6.8	30.1
19	Бусад эмнэлэг	Энэрэл	84		3403.5	70.0	31	0.9	6.3	40.5
20		Аддиктологи	95		3551.5	77.4	0	0.0	7.6	37.4
21		СЗКЭ	175		4868.0	104.8	1	0.02	13.8	27.8
22		Эрүүл үрс	55	55	432.0	16.8	0	0.0	7.8	7.9
23		Хантуул	70	70	50.0	10.4	0	0.0	7.6	5.0
24	Хувийн эмнэлэг		2332		86378.0	59.9	50	0.1	5.9	37.0
25	НЭМГ-т мэдээ өгдөг бусад эмнэлгийн дүн		1751	353	50053.0	60.6	110	0.2	7.7	28.6
	Бүгд		8084	1364	317833.5	69.2	1387	0.4	6.4	39.3

3.3. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ, ШАТЛАЛААР


Өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ

Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хуульд зааснаар иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх зорилгоор өрхийн нэг эрүүл мэндийн төвд ногдох иргэний тоог 8000-аас доошгүй байхаар тогтоосон байна. Өрхийн ЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны стандарт (MNS 5292:2017), Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан эрх зүйн 4 баримт бичгийн хэрэгжилтийг ханган, ажиллаж байна.

2023 оны байдлаар Улаанбаатар хотын 148 өрхийн эрүүл мэндийн төв, 11 салбарт 470 мянган өрхийн 1,697,997 хүн ам бүртгэлтэй байна. Өрхийн хүн амын бүтцийг насны ангиллаар авч үзвэл нийт хүн амын дотор 0-19 нас хүртэлх хүүхэд 39.5 хувь, хөдөлмөрийн насны буюу 20-49 насны хүмүүс 42.6 хувийг эзэлж байна.

Өрхийн хүн ам, насны ангиллаар, хувиар, 2023 он



Бүртгэлд хамрагдсан өрхийн 50.0 хувь нь эрүүл өрх, 35.1 хувь нь өвчлөлд бага өртөмтгий өрх, 14.9 хувь нь өвчлөлд өртөмтгий бүлгийн өрхүүд байна. Нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвд 846 их эмч, 786 сувилагч болон нийт 2440 ажиллагсад хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлсэн байна. Нийт ажиллагсдын 88.5 хувь эмэгтэйчүүд байна.

Өрхийн эрүүл мэндийн төвд 4,351,740 үзлэг хийгдэж, нэг иргэн дунджаар 2.6 удаа өрхийн эмнэлэгт хандаж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан байна.

2023 оны байдлаар өрхийн эрүүл мэндийн төвд хийгдсэн үзлэгт:

- урьдчилан сэргийлэх үзлэг 46.3 хувь
- идэвхтэй хяналтын үзлэг 7.1 хувь
- гэрийн идэвхтэй эргэлт 28.6 хувь
- амбулаторийн үзлэг 17.2 хувь
- гэрийн дуудлага 0.8 хувийг тус тус эзэлж байна.

Энэ нь өмнөх оны мөн үеэс урьдчилан сэргийлэх үзлэг 7.4, гэрийн идэвхтэй эргэлтийн үзлэг 4.7, гэрийн дуудлагын үзлэг 0.1 хувиар тус тус өссөн бол, амбулаторийн үзлэг 11.3, идэвхтэй хяналтын үзлэг 1.1 хувиар тус тус буурсан байна.

“Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-д гэрийн идэвхтэй эргэлтийн хувь 30-аас доошгүй байна гэж заасан байдаг.

Өрхийн эрүүл мэндийн төвийн үзлэгийн хэлбэр, 2014-2023 он

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	42.2	42.9	43.7	42.7	43.0	43.9	39.8	42.3	38.9	46.3
Гэрийн идэвхтэй эргэлтийн үзлэгийн хувь	28.4	28.3	29.0	29.9	29.2	27.8	34.0	30.2	23.9	28.6
Идэвхтэй хяналтаас эдгэрэлтийн хувь	37.2	29.8	32.1	33.2	26.5	26.2	25.9	25.3	34.3	27.4

Өрх, тосгоны ЭМТ-ийн тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлт, 2023 он

Үзүүлэлт	Өрхийн ЭМТ	Тосгоны ЭМТ
----------	------------	-------------

			Дүн
Эмнэлгийн тоо	148	4	152
Их эмчийн тоо	846	29	875
Сувилагчийн тоо	786	23	809
Орны тоо	-	62	62
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо		1746.0	1746.0
Дундаж ор хоног		6.9	6.9
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	4351740	54889	4406629
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	46.3	31.1	38.7
Нэг иргэний жилд үзүүлсэн удаа	2.7	1.9	4.6
Өрхийн нэг эмчид ногдох үзлэгийн тоо	5143.9	1892.7	7036.6
Жирэмсний эрт хяналтын хувь	91.6	79.1	85.4

Тосгоны эрүүл мэндийн төвд 29 их эмч, 23 сувилагч, 2 эх баригч, 2 эм найруулагч, 3 лаборант, нийт 113 ажиллагсад хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Нийт ажиллагсдын 81.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Тосгоны эрүүл мэндийн төвд 10077 өрхийн хүн ам бүртгэлтэй байна. Жилдээ 54889 мянган үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 1-2 удаа хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна.

Тав хүртэлх насны хүүхдийн хяналт, хувиар, 2013-2023 он



Өрх, тосгоны эрүүл мэндийн төвд 0-5 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналт 2018 онд 62.7, 2019 онд 61.8 хувь байсан бол 2021 онд 47.3, 2022 онд 53.2, 2023 онд 67.2 хувь байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний заавар батлах тухай” А/05 дугаар тушаалд 0-5 хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлт, хяналтыг:

- 2 хүртэлх сартай хүүхдийг 6-аас доошгүй удаа гэрээр 100% эргэх,
- 2 сараас 1 нас хүртэлх хүүхдийг сар бүр үзэж, 90 ээс доошгүй хувийг,
- 1-2 нас хүртэлх хүүхдийг улирал тутам үзэж, 80-аас доошгүй хувийг,
- 2-5 нас хүртэлх хүүхдийг хагас жил тутамд үзэж, 80-аас доошгүй хувийг хянаж байхаар заасан.

Улаанбаатар хотод дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг 9 эрүүл мэндийн төв, 4 нэгдсэн эмнэлэг, 3 амаржих газар хүн амд амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр эмнэлэгийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэгт их эмч 1156, сувилагч 1132 ажиллаж байна.

Дүүргийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ

Улаанбаатар хотын дүүргийн эрүүл мэндийн төвд 760 их эмч, 702 сувилагч 303 эмнэлгийн

тусгай мэргэжилтнүүд болон нийт 2585 эмнэлгийн ажилтан, албан хаагчид ажиллаж байна.

Дүүргийн эрүүл мэндийн төвийн 1558 эмнэлгийн оронд 55074 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн байна. Дундаж ор хоног 6.9, хэвтэн эмчлүүлэгчийн тоо өмнөх оноос 1925-аар буурсан үзүүлэлттэй байна. Хоног болоогүй нас баралтын хувь өмнөх оноос 3.4 хувиар буурсан. Амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо өмнөх оноос 660.6-аар өссөн байна.

Дүүргийн эрүүл мэндийн төвийн тусламж,и үйлчилгэний зарим үзүүлэлт, 2023 он

Үзүүлэлт	Дүүргийн эрүүл мэндийн төв									Нийт дүн
	Баянгол	Баянзүрх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	Налайх	Багануур	Багахангай	
Эмнэлгийн орны тоо	405		298		90	262	215	253	35	1558
Их эмчийн тоо	139	138	87	64	69	94	94	69	6	760
Сувилагчийн тоо	115	87	94	44	46	102	111	98	5	702
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	14719.5		8756.5		3901.5	9090	8385.5	9368	853	55074
Дундаж ор хоног	6.2		7.2		7.6	6.1	7.0	6.9	7.1	6.9
Фонд ашиглалтын хувь	61.6		58.0		90.2	58.2	74.5	69.6	47.1	65.6
Хоног болоогүй нас баралтын хувь	28.9		41.4		6.3	21.6	32.3	33.3	0.0	23.4
Амбулаторийн үзлэг	1095.4	1708.8	1379.4	818.5	883.0	798.9	245.2	215.9	52.8	7197.7
Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	36.4	36.9	36.3	30.2	46.5	44.3	22.0	25.2	43.2	35.7
Мэс заслын хагалгаа	20723	2371	2632	2175	1338	444	2721	1869		34273

Дүүргийн нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ

Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэгт 396 их эмч, 430 сувилагч, 105 эмнэлгийн тусгай мэргэжилтэн, нийт 1379 эмнэлэгийн ажилтан, албан хаагчид ажиллаж тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

Дүүргийн нэгдсэн эмнэлэгийн тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлт, 2023 он

Үзүүлэлт	СХНЭ	ХҮНЭ	СБНЭ	БЗНЭ	Нийт
Эмнэлгийн орны тоо	365	246	345	358	1314
Их эмчийн тоо	164	80	59	93	396
Сувилагчийн тоо	179	69	90	92	430
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	21150.5	16051.5	16457.5	16897.5	70557.0
Дундаж ор хоног	5.7	6.3	6.5	6.2	6.2
Хоног болоогүй нас баралтын хувь	16.9	0.0	23.8	22.5	15.8

Дүүргийн нэгдсэн эмнэлгийн 1314 оронд 70557.0 хүн хэвтэн эмчлүүлж, дундаж ор хоног 6.2 байгаа нь өмнөх оноос хэвтэн эмчлүүлэгчийн тоо 1754-өөр, дундаж ор хоног 0.1-ээр тус тус өссөн

үзүүлэлттэй байна. Эмнэлгийн хоног болоогүй нас баралтын хувь өмнөх оноос 4.8 хувиар буурсан байна.

Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй амаржих газруудад нийт 779 ажиллагсад ажиллаж байна. Нийт 175 их эмчийн 59.4 хувийг эх барих, эмэгтэйчүүдийн эмч, 12.6 хувийг эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн их эмч, 13.1 хувийг хүүхэд, нярайн эмч эзэлж байна.

Амаржих газрын тусламж, үйлчилгээний зарим, үзүүлэлт 2023 он

Үзүүлэлт	Өргөө	Хүрээ	Амгалан	Бүгд
Эмнэлгийн орны тоо	363	85	200	648
Их эмчийн тоо	74	34	67	175
Сувилагчийн тоо	96	21	34	151
Эх баригч бага эмч	49	35	60	144
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	20212.0	7497.5	14011.0	41720.5
Дундаж ор хоног	5.4	4.2	4.9	4.8
Хоног болоогүй нас баралтын хувь	20.9	33.3	22.2	25.5
Төрөлт	7030	3249	6462	16741
Эхийн эндэгдэл	2	2		4
Нярайн эндэгдэл	40	9	24	73
Мэс заслын хагалгаа	6981	2418	3806	13205

2023 онд амаржих газруудад 16741 эх амаржиж, 16827 хүүхэд амьд төрсөн байна. Нийт төрөлтийн 0.4 хувийг гэрийн төрөлт эзэлж байна. Амьгүй төрөлтийн түвшин 5.2, төрөлхийн гажигтай төрсөн нярай 0.5 хувь, бага жинтэй нярайн хувь 4.0 байна. Энэ нь өмнөх оноос 0.5, бага жинтэй нярайн хувь 1.1-ээр тус тус буурсан байна.

Нийт амаржих газрын 648 оронд 41720.5 хүн эмчлэгдэж, 209841 ор хоног ашигласан ба ор ашиглалтын хувь 93.0, дундаж ор хоног 4.8, орны эргэлт 71.3 байна. Эмнэлгийн нас баралт 79 тохиолдол бүртгэгдсэний 4 тохиолдол нь эхийн эндэгдэл, 73 нь нярайн эндэгдэл байна. Эмнэлгийн нас баралтын 25.5 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээ

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 51.5 хувийг хувийн эмийн сан, 32.6 хувийг хувийн клиник, 9.1 хувийг эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, 4.5 хувийг ортой хувийн эмнэлэг, 2.3 хувийг сувилал, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв эзэлж байна.


Эдгээр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 27.0 мянган ажиллагчид байгаагаас 32.8 хувь нь хувийн клиникт, 31.0 хувь нь хувийн эмийн сан, эм ханган нийлүүлэх, эмийн үйлдвэрт, 26.9 хувь нь ортой хувийн эмнэлэгт, 9.3 хувь нь сувилал, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төвд тус тус ажиллаж байна.

Улаанбаатар хотод 2023 оны жилийн эцсийн тайлан ирүүлэлтийн байдлаар нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа ор бүхий 78 эмнэлэг, 19 сувилал, 832 үүдэн эмнэлэг амбулатори, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн ба 1728 эмнэлэгт 3961 их эмч, 1736 сувилагч, нийт 14161 эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон бусад ажилчид ажиллаж байна.

Нийслэлийн эрүүл мэндийн газраас тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагын 47.0 хувь нь эмийн сан, 42.4 хувь нь клиник үүдэн эмнэлэг, 10.6 хувь нь нэгдсэн, ортой эмнэлэг,

сувилал, сэргээн засах төв, төрийн тусгай байгууллагын эмнэлгүүд байна.

Амбулаторийн үзлэг кабинетаар, хувиар



НЭМГ-ын харьяа хувийн эмнэлгүүд 2022 онд 2012356 амбулаторийн үзлэг хийсэн ба өмнөх оноос 339749-өөр өссөн байна. Амбулаторийн үзлэгийн 4.2 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, дийлэнх буюу 95.6 хувийг өвчний учир амбулаторийн үзлэг, 0.2 хувийг идэвхтэй хяналтын үзлэг эзэлж байна.

НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн нийт үзлэгийн 18.6 хувийг ХХЭМБ-ын үзлэг эзэлж байна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа хувийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлт, 2015-2023 он

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Ортой эмнэлгийн тоо	87	87	95	100	101	106	97	88	96
Үүдэн эмнэлгийн тоо	817	829	984	1102	1199	1053	1086	1458	1619
Эмнэлгийн орны тоо	1981	2076	2128	2253	2327	2332	2506	2332	3208
Эмчийн тоо	1811	1873	2174	2399	2568	2819	2897	3603	3961
Сувилагчийн тоо	1069	1033	1233	1234	1328	1320	1316	1607	1736
Амбулаторийн үзлэгийн тоо	1094.3	1125.1	1216.1	1260.1	1380.8	1208.8	1272.7	1672.6	2012.4
Эмчлэгдсэн өвчтөний тоо	53848	57217	56685	60530	63695	58384	62353	72644	86378
Дундаж хоног	ор 6.8	7.0	7.0	7.0	7.1	6.7	6.5	6.1	5.9

Хувийн хэвшлийн ор бүхий эмнэлгүүдийн тусламж үйлчилгээ


Ор бүхий эмнэлэгт 86378 хүн эмчлэгдэн гарч өнгөрсөн оны мөн үеэс 13735-аар өсч, 510239 ор хоног ашигласан ба орны фонд ашиглалтын хувь 42.8, дундаж ор хоног 5.9, орны эргэлт 26.9 байна. Эмнэлгийн нас баралт 50 бүртгэгдсэн байна.

Сувилалд 41697 хүн эмчлэгдэж, 291820 ор хоног ашигласан байна.

НЭМГ-ын харьяа хувийн ортой эмнэлгийн хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, 2023 он

Үзүүлэлт	Байгууллагын тоо	Хувь	Эмчлэгдсэн өвчтөний тоо	Хувь
5-9 ортой	4	4.2	257.5	0.3
10-14 ортой	9	9.4	4502.5	5.2
15-19 ортой	27	28.1	9977.5	11.6
20-25 ортой	21	21.9	20428	23.6
26-30 ортой	15	15.6	12881	14.9
31-50 ортой	5	5.2	13117	15.2
55 ба түүнээс дээш ортой	15	15.6	25214.5	29.2
Нийт дүн	96	100	86378.0	100

Ор бүхий эмнэлэгт эмчлэгдсэн өвчтөний тоо, тасгаар, 2023 он



БҮЛЭГ IV. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ХҮНИЙ НӨӨЦ

Монгол Улсын Эрүүл мэндийн салбарт 2023 онд нийт 66300 ажиллагсад Монгол Улсын 3.396.8 мянган хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 4.7 хувь буюу 2960 хүнээр нэмэгдсэн байна. Нийт ажиллагсдаас 92.5 хувь нь эрүүл мэндийн салбарын, 7.5 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажиллагсад эзэлж байна.

Улаанбаатар хотод нийт 2534 эрүүл мэндийн байгууллагад 39336 ажиллагсад ажиллаж байгаагаас удирдах ажилтан 1276, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн 718, мэдээлэл технологийн мэргэжилтэн 189, их эмч 9856, эм зүйч 2867, бусад дээд мэргэжилтэн 4333, эмнэлгийн тусгай мэргэжлийн мэргэжилтэн 11002 байгаагаас сувилагч 7902, эм найруулагч 1032, бага эмч 213, техникч 764, лаборант 690, эх баригч 401 тус тус ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарын нийт ажиллагсдыг эмнэлгийн төрлөөр нь ажиллагсдыг харьцуулбал:

- Сум тосгоны эрүүл мэндийн төвд 12.5%;
- Хувийн клиникт 13.4%;
- Хувийн эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэрт 12.6%;
- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, ортой хувийн эмнэлэгт 10.6%;
- Аймгийн нэгдсэн эмнэлэгт 8.1%;
- Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд 6.1%;
- Өрхийн эрүүл мэндийн төвд 5.7 хувь нь ажиллаж байна.

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт ажиллагсдын:

- өрх, тосгоны эрүүл мэндийн төвд 9.8;
- дүүргийн эрүүл мэндийн төвд 9.9;
- нэгдсэн эмнэлэгт 5.3;
- тусгай эмнэлэгт 3.6;
- амаржих газарт 3.0;
- түргэн тусламжийн төвд 1.6;
- хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харъяа эрүүл мэндийн байгууллагад 1.0;
- төмөр замын төв эмнэлэгт 1.7;
- хувийн эмнэлэг, эмийн сангуудад 54.4;
- боловсролын байгууллагад 6.1;
- ЭМЯ, ЭМХТ, НЭМГ-т 0.7;
- бусад салбарын эрүүл мэндийн байгууллагад 2.0 хувь нь ажиллаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын 81.8 хувь нь эмэгтэйчүүд, 18.2 хувь нь эрэгтэйчүүд байна.

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллагсдыг хүйсээр харьцуулбал:

- өрх, тосгоны эрүүл мэндийн төвд 65.7;
- дүүргийн эрүүл мэндийн төвд 71.2;
- нэгдсэн эмнэлэгт 77.5;
- тусгай эмнэлэгт 79.7;
- амаржих газарт 81.7;
- хувийн эмнэлэг, эмийн сангуудад 80 буюу эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.

Эрүүл мэндийн салбарын ажиллагсад, 2023он

	Үзүүлэлт	Улсын хэмжээнд	Улаанбаатарт
Нийт ажиллагсад	Бодит тоо	66266	39336
	10000 хүн амд	189.1	239.7
	Үүнээс		
Их эмч	Бодит тоо	14978	9856
	10000 хүн амд	44.3	60.0
Сувилагч	Бодит тоо	14494	7902
	10000 хүн амд	41.4	48.1
Эх баригч	Бодит тоо	1162	401
	10000 хүн амд	3.3	2.4
Лаборант	Бодит тоо	1407	690
	10000 хүн амд	4.0	4.2
Техникч	Бодит тоо	997	764
	10000 хүн амд	2.8	4.6
Эм найруулагч	Бодит тоо	2204	1032
	10000 хүн амд	6.3	6.2
Бага эмч	Бодит тоо	1653	213
	10000 хүн амд	4.7	1.3
Бусад	Бодит тоо	1790	1542
	10000 хүн амд	5.1	4.4


Насны бүтцээр авч үзэхэд 24 хувь нь 29 хүртэлх нас, 32.0 хувь нь 30-39 насны, 21.0 хувь нь 40-49 насны, 10.5 хувь нь 50-54 насны, 6.5 хувь нь 55-59 насны, 6.2 хувь нь 60-аас дээш насныхан эзэлж байна. Нийт ажиллагсдын 81.8 хувь нь эмэгтэй, 18.2 хувь нь эрэгтэй байна.

Улаанбаатар хотод нэг эмчид ногдох хүний тоо 164, нэг сувилагчид ногдох хүний тоо 205 байна. Нийт их эмч нарын 7.8 хувийг уламжлалт анагаахын, 15.7 хувийг нүүр амны их эмч, 76.5 хувийг бусад мэргэшлийн хүний их эмч тус тус эзэлж байна. Хүний их эмч нарын 11.7 хувь нь ерөнхий мэргэжлийн, 10.1 хувь нь дотор, 4.0 хувь нь хүүхэд, 6.5 хувь нь эх барих эмэгтэйчүүд, 3.8 хувь нь дүрс оношилгоо, 1.6 хувь нь лаборатори, 5.1 хувь нь мэс засал, 3.2 хувь нь мэдрэл, 2.3 хувь нь мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний эмч нар эзэлж байна.

Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй их эмч нарын 2223 буюу 22.5 хувь магистрын зэрэгтэй ба үүнээс 259 нь тухайн онд зэрэг хамгаалсан ба 15.1 хувь нь докторын зэрэгтэй байна. Их эмч нарын мэргэжлийн зэрэг: 13.7 хувь нь ахлах, 10,8 хувь нь тэргүүлэх, 3.1 хувь зөвлөх зэрэгтэй байна.

Монгол улсын эрүүл мэндийн салбарт 2023 оны байдлаар нийт 14494 сувилагч ажиллаж байгаагийн 50.8 хувь нь бакалавр, 39.8 хувь дипломын боловсролтой ба 9.4 хувь нь туслах сувилагч байна. Эмнэлгийн сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн 15.4 хувь нь ахлах, 8.8 хувь нь тэргүүлэх зэрэгтэй, 2.0 хувь нь магистрын зэрэгтэй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд ажиллаж байна.

Нийт ажиллагсад, их эмч, тусгай мэргэжилтэн, 10000 хүн амд, Улаанбаатар, 2013-2023 он




Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагын эмч ажиллагсад, бодит тоогоор, 2023 он

Эрүүл мэндийн байгууллага		Нийт ажиллагчид	Их эмч	Сувилагч	Эмч сувилагчийн харьцаа
Өрхийн эрүүл мэндийн төв		2440	846	786	1:0.9
Тосгоны эрүүл мэндийн төв		1379	396	430	1:0.8
Эрүүл мэндийн төв	Баянгол	430	139	115	1:0.8
	Баянзүрх	388	138	87	1:0.6
	Сонгинохайрхан	354	87	94	1:1.1
	Сүхбаатар	210	64	44	1:0.7
	Хан-Уул	202	69	46	1:0.7
	Чингэлтэй	336	94	102	1:1.2
	Налайх	336	94	111	1:1.2
	Багануур	299	69	98	1:1.4
	Багахангай	30	6	5	1:0.8
Нэгдсэн эмнэлэг	Баянзүрх	275	93	92	1:1
	Сонгинохайрхан	554	164	179	1:1.1
	Сүхбаатар	271	59	90	1:1.5
	Хан-Уул	279	80	69	1:0.9
Амаржих газар	Өргөө	355	74	96	1:1.3
	Хүрээ	157	34	21	1:0.6
	Амгалан	267	67	34	1:0.5
Хувийн эмнэлэг	Ортой	2171	724	431	1:0.6
	Клиник	6798	3009	1170	1:0.4
	Сувилал	741	200	134	1:0.9
Бусад эмнэлэг		3505	709	698	1:1
Нийт		24962	6876	4526	1:0.7

Улсын хэмжээнд 30 гаруй төрлийн цочмог халдварт өвчний 41.0 мянган тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 121.4 байна. Нийт халдварт өвчний 39.1 хувь амьсгалын замын халдварт өвчин, 25.0 хувь бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 18.8 хувь гэдэсний халдварт өвчин, 0.8 хувь зоонозын халдварт өвчин, 16.3 хувь бусад халдварт өвчин эзэлж байна.

Улаанбаатар хотод халдварт өвчний нийт 21019 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 134.1 байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 168054 тохиолдол буюу 10000 хүн амд ногдох өвчлөл 1110.5-аар буурсан байна.

Бүртгэгдсэн халдварт өвчин, 10000 хүн амд, 2013-2023 он



Халдварт өвчний бүтэц 10000 хүн амд, 2023 он

Нийт халдварт өвчин	2022		2023		Өсөлт /бууралт/	
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
Бэлгийн замаар дамжих халдвар	6272	41.2	6059	38.6	-213	-2.6
Гэдэсний халдварт өвчин	1467	9.6	2091	13.3	624	3.7
Бусад халдварт өвчин	1240	8.2	1775	11.3	535	3.1
Амьсгалын замын халдварт өвчин	180072	1244.6	11055	70.5	-169017	-1174.1
Зоонозын халдварт өвчин	22	0.1	39	0.2	17	0.1

Нийт халдварт өвчний 52.6 хувийг амьсгалын замын халдварт өвчин, 28.8 хувийг бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 8.4 хувийг бусад халдварт өвчин, 9.9 хувийг гэдэсний халдварт өвчин, 0.2 хувийг зоонозын халдварт өвчин тус тус эзэлж байна.

5.1. АМЬСГАЛЫН ЗАМЫН ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН

Амьсгалын замын халдварт өвчин 2023 онд улсын хэмжээнд сүрьеэ, салхинцэцэг, ёлом, улаан эсэргэнэ, гахайн хавдар, менингококкт халдвар, улаанууд, эритема зэрэг 8 гаруй төрлийн 16033 тохиолдол бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотод амьсгалын замын халдварт өвчний 11055 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 169017 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 70.5 тохиолдол бүртгэгдсэн байна.

Амьсгалын замын халдварт өвчний бүтэц, 10000 хүн амд 2022-2023 он


Амьсгалын замын халдварт өвчин	2022		2023		Өсөлт /бууралт/	
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
Менингит	1	0.01	3	0.02	2	0.01
Гахай хавдар	8	0.05	115	0.73	107	0.68
Улаан эсэргэнэ	93	0.6	1033	6.59	940	5.99
Улаанууд	1	0.01	0	0.0	-1	-0.01
Сүрьеэ	1386	9.1	1410	9.0	24	-0.1
Салхинцэцэг	1464	9.6	5969	38.07	4505	28.47
Гар хөл амны өвчин	1021	6.7	2525	16.11	1504	9.41

Гахай хавдар

Улсын хэмжээнд гахай хавдар өвчний 206 тохиолдол бүртгэгдсэний 115 нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. 10000 хүн амд 0.73 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 107 тохиолдол буюу 10000 хүн амд 0.68-аар буурсан байна.

Гахай хавдар өвчний нийт тохиолдол 0-10 насныхан бүртгэгдсэн байна. Ялангуяа 5-9 насны хүүхдүүд нийт тохиолдлын 50 хувийг эзэлж байгаа нь цэцэрлэг болон сургуулийн насныханд илүү тохиолдсон байна.


Гахай хавдар өвчний хөдлөл зүй, бодит тоо, сараар, 2022-2023 он



Салхинцэцэг


Улсын хэмжээнд салхинцэцэг өвчний 11878 тохиолдол бүртгэгдсэний 42.2 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотод өвчлөлийн 5969 тохиолдол бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 10000 хүн амд 28.5-аар өссөн байна.

Салхинцэцэг өвчний хөдлөл зүй сараар, бодит тоо, 2023 он



Улиралчлал: Салхинцэцэг өвчний эпидемиологийн хөдлөл зүйг авч үзэхэд 2 ба 3 сард бага, 1 ба 6-р сард огцом ихэсч 9 сард буурч 12-р сараас ихэссэн үзүүлэлттэй байна.

Салхинцэцэг өвчин, насны ангиллаар, хувиар, 2023 он



Насны бүтцээр авч үзэхэд 84.4 хувь нь 0-15 насны хүүхэд байгаа бол үүнээс 37.8 хувь нь сургуулийн, 52.2 хувь нь цэцэрлэгийн насны хүүхдүүд байна.

Менингококкт халдвар

Улсын хэмжээнд менингококкт халдварын 6 тохиолдол бүртгэгдсэн байна. Нийслэлд менингококкт халдварын 3 тохиолдол, Дорнод аймагт 3 тохиолдол бүртгэгдсэн байна.

Гар, хөл, амны өвчин

Улсын хэмжээнд гар хөл амны өвчний 4217 бүртгэгдсэн бол Улаанбаатар хотод гар, хөл, амны өвчлөлийн 59.8 хувь буюу 2525 тохиолдол бүртгэгдсэн байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гар, хөл, амны өвчний 96.1 хувийг 0-9 насны хүүхдийн өвчлөл эзэлж байна. Улаанбаатар хотод гар, хөл, амны өвчлөл 10000 хүн амд 16.1 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 9.4-өөр нэмэгдсэн байна. Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт Улаанбаатар хотын дунджаас өндөр байна. Нийт өвчлөлийн 43.2 хувь нь Баянзүрх, 9.4 хувь нь Сонгинохайрхан, 14.9 хувь нь Хан-Уул, 10.8 хувь нь Сүхбаатар, 10.5 хувь нь Баянгол, 8.9 хувь нь Чингэлтэй, 1.0 хувь нь Налайх, 1.2 хувь нь Багануур дүүрэгт бүртгэгдэж Багахангай дүүрэгт өвчлөл бүртгэгдээгүй байна. Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн гар, хөл, амны өвчний 99.8 хувь нь эмнэл зүйгээр, 0.2 хувь нь эмнэл зүйн лабораторийн давхар шинжилгээгээр тус тус онош тогтоогдсон байна.


Сүрьеэ

Монгол улс Номхон далайн баруун бүсийн орнуудаас өвчлөл өндөртэй 7 орны тоонд ордог бөгөөд өвчлөлийн талаас илүү хувь нь улсын нийслэлд бүртгэгддэг.

Улсын хэмжээнд сүрьеэ өвчний нийт 2357 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 5.7 хувийг эзэлж байна. 10000 хүн амд ногдох түвшин 7.0 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 1020 (10000 хүн амд 3.8) тохиолдлоор буурсан боловч өмнөх оноос 2 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна. Шинэ тохиолдлын дотор уушигны сүрьеэ 1674 (71.0%), уушигны бус эрхтний сүрьеэ 683 (29.0%) бүртгэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулбал уушигны сүрьеэ 26 тохиолдлоор буурч, уушигны бус эрхтний сүрьеэ 28 тохиолдлоор нэмэгдсэн ба уушигны сүрьеэгийн эзлэх хувь 1.2 %-р буурсан байна.

Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн нийт өвчлөлийн 1410(59,8%) нь УБ хотод, 947 (40,2%) нь аймаг орон нутагт бүртгэгдсэн байна. Улаанбаатарт бүртгэгдсэн тохиолдлын дотор уушигны сүрьеэ 1002(71,1 /%), уушигны бус эрхтний сүрьеэ 408(28,9%) бүртгэгдсэн байна.

Сүрьеэгийн өвчин, 10000 хүн амд, сүүлийн 10 жилээр




Улаанбаатар хотод сүрьеэгийн өвчлөлийн 1410 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчлөлийн 6,7 хувийг эзэлж байна. 10000 хүн амд ногдох сүрьеэгийн өвчлөл 9.0 байгаа нь өмнөх оноос 0.1-ээр буурсан байна.

Сүрьеэгийн өвчин, 10000 хүн амд, дүүргээр, 2022-2023 он

Дүүргийн ЭМТ	2022		2023		"Өсөлт /бууралт/"
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо
Баянгол	167	7.1	163	6.7	4
Баянзүрх	309	8.2	357	9	-48
Сонгинохайрхан	329	9.7	343	10	-14
Сүхбаатар	79	5.5	93	6.5	-14
Хан-Уул	169	8.3	163	7.3	6
Чингэлтэй	207	13.7	133	9	74
Налайх	31	8	35	8.9	-4
Багануур	8	2.7	22	7.5	-14
Багахангай	8	17.9	3	6.8	5
Бусад эмнэлэг	79	-	98	-	-19
Улаанбаатар	1386	9.1	1410	9	-24

2023 онд 10000 хүн амд ногдох өвчлөл Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд нийслэлийн дундаж үзүүлэлтээс өндөр байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн сүрьеэгийн нийт тохиолдлын 59.8 хувь Улаанбаатар хотод, 72.7 хувийг Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол, Хан-уул дүүргийн харьяаллын хүн амын өвчлөл эзэлж байна.

Сүрьеэгийн шинэ өвчлөл, насны ангиллаар, хувиар, 2023 он



Шинээр илэрсэн сүрьеэтэй өвчтөний 57.5 хувийг 15-44 насныхан эзэлж байгаа нь залуу хөдөлмөрийн насны хүмүүс илүүтэй өвчилж байгааг харуулж байна. Хүйсийн хувьд 59.7 хувийг эрэгтэйчүүд 40.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Улсын хэмжээнд 0-15 хүртэлх насны хүүхдийн сүрьеэгийн 161 тохиолдол бүртгэгдсэн нь нийт сүрьеэгийн шинэ өвчлөлийн 6.8 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод 105 хүүхэд сүрьеэгээр өвчилсөн нь нийт хүүхдийн сүрьеэгийн өвчлөл дотор 65.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 1.1 хувиар буурсан байна.

Сүрьеэ өвчлөлийн түвшин 100 000 хүн амд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2005	2010	2015	2020	2021	2022	2023
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин									
Улсын дундаж	79.0	125.0	178.0	154.0	144.0	103.5	72.2	70.5	69.7
УБ хот	84.0	155.0	244.0	189.0	183.7	138.8	95.5	88.4	89.9
Аймгийн дундаж	63.0	99.0	123.0	136.0	105.4	73.5	49.3	54.7	53.4
Сүрьеэгийн нас баралтын түвшин									
Улсын дундаж	4.8	3.2	4.0	3.3	3.6	3.0	1.8	2.0	2.7
УБ хот	5.4	2.5	0.3	4.4	5.4	4.0	2.6	2.6	4.0
Аймгийн дундаж	3.9	2.0	4.3	2.5	2.0	2.1	1.0	1.4	1.6
Сүрьеэгийн эмчилгээний амжилтын хувь									
Улсын дундаж	-	100/80	100/79	100/84.5	100/79.5	100/76.4	100/77.6	100/76.5	100/75.0
УБ хот	-	100/84	100/74	100/81.7	100/74.3	100/67.7	100/72.8	100/71.2	100/69.2
Аймгийн дундаж	-	100/81	100/84	100/87.5	100/87.8	100/87.1	100/84.7	100/86.1	100/83.4

Коронавируст халдвар (ковид-19)

2023 онд улаанбаатар хотод коронавируст халдварын 1469 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 9.4 байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 175660 тохиолдлоор буюу 10000 хүн амд 1156.5-аар буурсан байна. Коронавирусын халдварын нас баралтын 3 тохиолдол бүртгэгдсэн байна.

5.2. ГЭДЭСНИЙ ХАЛДВАР

2023 онд Улаанбаатар хотод гэдэсний халдварт өвчний 2091 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 624 тохиолдлоор өссөн байна. Гэдэсний халдварт өвчний 83.4 хувь нь цусан суулга, 6.0 хувь нь хоолны хордлого, 9.4 хувь нь сальмонеллэз, 1.2 хувь нь халдварын гаралтай гастроэнтерит ба суулгалт өвчин тус тус эзэлж байна.

Гэдэсний халдварт өвчний бүтэц, хувиар, 2023 он



Цусан суулга

Гэдэсний халдварт өвчний 83.4 хувийг цусан суулга өвчин эзэлж байна. Цусан суулга өвчний 1744 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 11.1 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.4-өөр нэмэгдсэн байна.

Нийслэлд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 3.5 хувь нь хөдөө орон нутгийн хаягтай, 96.5 хувь нь улаанбаатрын хаягтай байна. Дүүргүүдээр харьцуулахад: Баянзүрх дүүрэгт хотын дунджаас өндөр байна. Нийт цусан суулга өвчлөлийн 32.8 хувь нь Баянзүрх, 23.5 хувь нь Сонгинохайрхан, 8.3 хувь нь Чингэлтэй, 10.8 хувь нь Баянгол, 9.0 хувь нь Сүхбаатар, 13.3 хувь нь Хан-Уул, 0.6 хувь нь Налайх, 1.7 хувь нь Багануур, 0.1 хувь нь Багахангай дүүрэгт тус тус бүртгэгдсэн байна. Цусан суулга өвчний 99.6 хувь нь эмнэл зүйгээр, 0.4 хувь нь эмнэл зүйн лабораторийн давхар шинжилгээгээр тус тус онош тогтоогдсон байна.

Сальмонеллэз

Улсын хэмжээнд сальмонеллэз өвчний 351 тохиолдол бүртгэгдсэн бол Улаанбаатар хотод сальмонеллэзын өвчлөлийн 197 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1.2 байна. Өмнөх онтой харьцуулахад 24 тохиолдлоор буурсан байна.


Гэдэсний халдварт өвчин, бодит тоо, 10000 хүн амд, 2022-2023 он

Халдварт өвчин /ӨУА-10/	2022		2023		Өсөлт /бууралт/	
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
Балнад	0	0	0	0	0	0
Сальмонеллэз	173	1.1	197	1.2	24	0.1
Цусан суулга	1324	8.7	1744	10.3	420	1.6
Хүнсний гаралтай бактери хордлого	16	0.11	125	0.7	109	0.59
Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга өвчин	1	0.01	25	0.1	24	0.09

Вируст гепатит

Улсын хэмжээнд вируст гепатит өвчний 270 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0.8 байна. Улаанбаатар хотод вируст гепатитийн 196 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1.2 байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 69 тохиолдлоор буюу 10000 хүн амд 0.4-өөр нэмэгдсэн байна. Нийт тохиолдлын 39.8 хувийг вируст гепатит В, 59.2 хувийг вируст гепатит С, 1.0 хувийг бусад вируст гепатит тус тус эзэлж байна.

Гэдэсний халдварт өвчний зарим тохиолдол, 10000 хүн амд, 2014-2023 он




5.3. БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАР

Улсын хэмжээнд зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын 10245 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 45.5 байна. Нийслэлд зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварт өвчний 6059 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 38.6 байна. Нийт тохиолдлын 24.6 хувь нь заг хүйтэн, 17.6 хувь нь трихомониаз, 43.6 хувийг нь тэмбүү, 14.2 хувийг бусад өвчлөл тус тус эзэлж байна.

Монгол улсад ХДХВ/ДОХ-ын халдварын анхны тохиолдол 1992 онд бүртгэгдсэнээс хойш 2023 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 369 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1.03 байна. Үүнээс 23 тохиолдол нь 2023 онд шинээр бүртгэгдсэн байна. Нас баралтын 51 тохиолдол бүртгэгдсэн. Нийслэлд 2023 онд ХДХВ/ДОХ-ын шинэ тохиолдол 21 бүртгэгдсэн.


Зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин, 10000 хүн амд, 2014-2023 он



Зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин 10000 хүн амд харьцуулахад улсын дунджаас

8.3-аар өндөр байна.

Зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин, 10000 хүн амд, 2014-2023 он



2023 онд тэмбүү өвчний 2647 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 16.9 байна. Тэмбүүгээр өвчлөгчдийн 0.8 хувь нь 0-9 насны хүүхэд, 12.2 хувь нь 10-19 насныхан, 68.9 хувь нь 20-39 насны, 18.1 хувийг 40-өөс дээш насны хүмүүс эзэлж байна

Төрөлхийн тэмбүү

Улсын хэмжээнд төрөлхийн тэмбүүгийн 31 өвчлөл бүртгэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 11 тохиолдлоор буурсан байна. Улаанбаатар хотод нийт 19 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 55.4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 6 тохиолдол буюу 18.5-аар өссөн байна.

Тогтмол хаягаар нь авч үзэхэд: Сонгинохайрхан-1, Сүхбаатар-1, Баязүрх-6, Багануур-1, Хан-Уул 2, Налайх -1, хөдөө орон нутгийн харьяалалтай 7 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Заг хүйтэн өвчний 1495 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 9.5 байна. Өмнөх онтой харьцуулахад 10000 хүн ам тутамд 0.3-аар нэмэгдсэн байна. Гэр бүлийн байдлын хувьд 67.5 хувь нь огт гэрлээгүй, 22.4 хувь нь батлуулсан гэр бүлтэй, 8.2 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй, 0.7 хувь нь тусгаарласан, 0.9 хувь нь цуцласан, 0.3 хувь нь бэлэвсэн байна.

Трихомониазын халдварын 1069 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 6.8 байна. Өмнөх онтой харьцуулахад өвчлөл 10000 хүн ам тутамд 1.1-ээр буурсан байна.

Трихомониазын халдварын дийлэнх хувийг 20-39 насныхан эзэлж байгаа ба гэр бүлийн байдлын хувьд 32.6 хувь нь огт гэрлээгүй, 59.6 хувь нь батлуулсан гэр бүлтэй, 28.2 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй, 1.2 хувь нь тусгаарласан, 2.1 хувь нь цуцласан, 0.4 хувь нь бэлэвсэн байна.

Халдварт өвчний шалтгаант нас баралтын мэдээлэл

2023 онд нийслэлд халдварт өвчний шалтгаант нас баралтын нийт 244 тохиолдол бүртгэгдсэн байна. Шалтгаанаар авч үзэхэд: Коронавируст халдвар 3, сүрьеэ 161, хумхаа 1, төрөлх тэмбүү 4, үжил 69, вируст гепатит 4, бусад 2 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

БҮЛЭГ VI.ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ


6.1 ХҮН АМЫН НИЙТ ӨВЧЛӨЛ

Албан ёсны статистик мэдээгээр улсын хэмжээнд нийт өвчлөлийн 3.6 сая (давхардсан тоогоор) тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 11259.7 байна. Улаанбаатар хотод хүн амын өвчлөлийн 1615759 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 9982.7 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд:

Өвчний бүлэг	Улс	Улаанбаатар
Амьсгалын тогтолцооны өвчин	1930.8	1389.4
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	2083.1	1698.2
Зүрх судасны тогтолцооны өвчин	1376.9	1086.6
Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	1150.3	1001.6
Гэмтэл, хордлого гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	764.7	1062.3

Зураг 6.1.1 Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд 2014-2023 он



Хоол боловсруулах тогтолцооны өвчин 10000 хүн амд 1698.2 байгаа нь өмнөх оноос 134.8-өөр нэмэгдсэн байна. Нийт өвчлөгсдийн 39.4 хувь нь эрэгтэйчүүд, 60.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Өвчлөлийг насны ангиллаар авч үзвэл 28.8 хувь нь 20 хүртэлх нас, 29.4 хувь нь 20-44 нас, 30.0 хувь нь 45-65 нас, 11.8 хувь нь 65 дээш нас байна.

Хүснэгт 6.1. Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйс 10 000 хүн амд 2023 он


Үзүүлэлт	Нийт өвчлөл	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Зүрх судасны тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	Гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант тодорхой эмгэг
Хүйс						
Эрэгтэй	8217.9	1354.1	823.5	1378.4	513.7	1123.2
Эмэгтэй	12258.9	2126.4	1400.7	1486.8	1520.7	802
Насны бүлэг						
Эрэгтэй						
20 хүртэлх	7562.8	1187.5	66.3	2071.8	321.3	1352.2
20-44 нас	5302.4	885.4	435.0	631.8	334.5	1205.5
45-65 нас	10647.5	1912.8	2133.0	873.0	783.6	1018.4
65 ба түүнээс дээш	21922.8	3426.4	5636.4	1652.4	2434.8	839.4
Эмэгтэй						
20 хүртлэх	7164.0	1359.0	62.0	1931.1	356.0	876.0
20-44 нас	10304.6	1756.1	726.3	941.3	2016.0	815.8
45-65 нас	18022.2	3160.2	3117.9	1263.4	2122.2	1025.0
65 ба түүнээс дээш	27352.5	4112.8	6962.4	1686.3	2622.6	1119.2
Улаанбаатарын дундаж	7164.0	1359.0	62.0	1931.1	356.0	876.0
Улсын дундаж	11259.7	2083.1	1376.9	1930.8	1150.3	764.7

Улаанбаатар хотын хүн амын тэргүүлэх 5 шалтгааныг улсын хэмжээнд харьцуулахад 10000 хүн амд гэмтэл хордлого гадны шалтгаант бусад тодорхой эмгэг 297.6-аар их, хоол боловсруулах тогтолцооны эмгэг 384.9-өөр, амьсгалын замын тогтолцооны өвчин 541.4-өөр, зүрх судасны тогтолцооны өвчин 290.3-аар, шээс бэлгийн тогтолцооны эмгэг 148.7-аар тус тус бага үзүүлэлттэй байна.

6.1.1 ХООЛ БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦООНЫ ӨВЧЛӨЛ

Улаанбаатарын хэмжээнд 10 000 хүн амд ногдох хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 1698.2 болж нийт өвчлөлийн 17.0 хувийг эзэлж байгаа ба сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 316.5-аар, өмнөх онтой харьцуулахад 134.8-аар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 6.2 Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 10 000 хүн амд, байршлаар




Зураг 6.3 Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 10 000 хүн амд, хүйс, дүүргээр 2023 он



Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн түвшнийг хүйсээр харуулбал, 10000 хүн амд Сүхбаатар дүүрэгт эрэгтэй 839.3, Баянгол дүүрэгт эрэгтэй 105.7, Баянзүрх дүүрэгт 17.8, Налайх дүүрэгт эрэгтэй 1160.2-оор тус тус Улаанбаатарын дундажаас их байна.

Зураг 6.4. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл насны бүлгээр, 10 000 хүнд ногдох 2023 он



10 000 хүн амд хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн түвшнийг ногдох насны бүлгээр Улаанбаатар хот, улсын хэмжээтэй харьцуулахад 65-аас дээш насанд хамгийн их буюу 3852.9 байгаа нь улсын хэмжээнээс 12.5-аар их байна.

Хүснэгт 6.2 Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, тэргүүлэх шалтгаан, дүнд эзлэх хувиар 2013, 2023 он


Тэргүүлэх өвчлөлүүд	2013 он			2023 он		
	эрэгтэй	эмэгтэй	бүгд	эрэгтэй	эмэгтэй	бүгд
Амны хөндий, шүлсний булчирхай ба гэдэсний өвчин	15.3	14.7	14.9	41	40.5	40.7
Улаан хоолой, ходоод гэдэсний өвчин	3	1.7	2.1	21.1	23.6	22.6
Элэгний өвчин	20.9	16	17.6	10.5	9	9.6
Цэсний хүүдий, цэсний зам ба нойр булчирхайн өвчин	22.3	34.8	30.8	12.1	16.8	15
Халдварт бус энтерит ба колит	1	0.5	0.7	3.6	2.3	2.8
Мухар олгойн өвчин	4.6	4	4.2	1.2	1.2	1.2
Хоол боловсруулах тогтолцооны бусад өвчин	32.9	28.3	29.7	10.5	6.6	8.1

2023 оны байдлаар амны хөндийн, шүлсний булчирхай ба эрүүний өвчин 2013 оноос 20.5 хувиар улаан хоолой, ходоод, дээд гэдэсний өвчин 2.8 хувиар, халдварт бус энтерколит 2.1 хувиар нэмэгдэж, цэсний хүүдий, цэсний зам ба нойр булчирхайн өвчин 15.8 хувиар, элэгний өвчин 8.0 хувиар, мухар олгойн өвчин 3.0 хувиар буурсан байна.


6.1.2 АМЬСГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ӨВЧЛӨЛ

Улаанбаатарын хэмжээнд 10 000 хүн амд ногдох амьсгалын тогтолцооны өвчлөл 1389.4 болж нийт өвчлөлийн 13.9 хувийг эзэлж байгаа ба сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 25.1-ээр буурч, өмнөх онтой харьцуулахад 174.7-оор нэмэгдсэн байна.

Зураг 6.5 Амьсгалын тогтолцооны өвчлөл 10 000 хүн амд, байршлаар




Зураг 6.6 Амьсгалын тогтолцооны өвчлөл 10 000 хүн амд, хүйс, дүүргээр 2023 он



Амьсгалын тогтолцооны өвчлөлийн түвшнийг хүйсээр харуулбал,10 000 хүн амд Баянгол дүүрэгт эрэгтэй 398.3,Сүхбаатар дүүрэгт эрэгтэй 1468.5, Налайх дүүрэгт эрэгтэй 919.9, Багахангай дүүрэгт эрэгтэй 301.5-аар тус тус Улаанбаатарын дундажаас их байгаа бол эмэгтэй хүйсийн хувьд Баянгол дүүрэгт эмэгтэй 326.0, Сүхбаатар дүүрэгт эмэгтэй 1567.8, Налайх дүүрэгт эмэгтэй 812.2, Багахангай дүүрэгт эмэгтэй 905.5-аар тус тус Улаанбаатарын дундажаас их байна.

Зураг 6.7 Амьсгалын тогтолцооны өвчлөл насны бүлгээр,10 000 хүнд ногдох 2023 он



Амьсгалын тогтолцооны өвчлөлийн түвшнийг насны бүлгээр Улаанбаатар хот, улсын хэмжээтэй харьцуулахад 0-4-аас насанд 4251.8 хамгийн их байгаа ба улсын хэмжээнээс 2520.5-р бага байна.


Хүснэгт 6.3 Амьсгалын тогтолцооны өвчлөл, дүнд эзлэх хувиар

Тэргүүлэх өвчлөлүүд	2014 он			2023 он		
	эрэгтэй	эмэгтэй	бүгд	эрэгтэй	эмэгтэй	бүгд
Амьсгалын дээд замын цочмог халдвар	23.2	27.4	50.6	15.5	16.4	31.8
Амьсгалын доод замын бусад цочмог халдвар	4.2	4.7	8.9	7.0	6.5	13.5
Томуу ба уушгины хатгалгаа	7.7	8.7	16.4	4.2	4.6	8.8
Амьсгалын дээд замын бусад өвчин	5.4	7.9	13.3	13.6	16.9	30.5
Амьсгалын доод замын архаг өвчин	3.5	5.3	8.8	5.4	8.3	13.7


6.1.3 ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧЛӨЛ

Улаанбаатарын хэмжээнд 10 000 хүн амд ногдох зүрх судасны тогтолцооны өвчлөл 1086.6 болж нийт өвчлөлийн 10.9 хувийг эзэлж байгаа ба сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 151.5, өмнөх онтой харьцуулахад 73.2-оор тус тус нэмэгдсэн байна.

Зураг 6.8 Зүрх судасны тогтолцооны өвчлөл 10 000 хүн амд, байршлаар




Зураг 6.9 Зүрх судасны тогтолцооны өвчлөл 10 000 хүн амд, хүйс, дүүргээр 2023 он



10 000 хүн амд зүрх судасны тогтолцооны өвчлөлийн түвшнийг хүйсээр харуулбал, Баянгол дүүрэгт эрэгтэй 254.6, Сүхбаатар дүүрэгт эрэгтэй 508.0, Налайх дүүрэгт эрэгтэй 701.2, Багахангай дүүрэгт 711.8-аар Улаанбаатрын дундажаас их байгаа бол эмэгтэй хүйсийн хувьд Баянгол дүүрэгт эмэгтэй 512.0, Сүхбаатар дүүрэгт эмэгтэй 861.2, Налайх дүүрэгт эмэгтэй 1318.5, Багахангай дүүрэгт эмэгтэй 2298.9-өөр Улаанбаатрын дундажаас их байна.

Зураг 6.7 Зүрх судасны тогтолцооны өвчлөл насны бүлгээр, 10 000 хүнд ногдох 2023 он



Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн түвшнийг насны бүлгээр Улаанбаатар хот, улсын хэмжээтэй харьцуулахад 65-аас дээш насанд 7658.7 хамгийн их буюу улсын хэмжээнээс 141.6-аар бага байна.


Хүснэгт 6.4 Зүрх судасны тогтолцооны өвчлөл тэргүүлэх шалтгаан, дүнд эзлэх хувиар 2014, 2023 он

Тэргүүлэх өвчлөлүүд	2014 он			2023 он		
	эрэгтэй	эмэгтэй	бүгд	эрэгтэй	эмэгтэй	бүгд
Артерийн даралт ихсэх, I11-I15	5.7	6.0	5.9	15.8	18.4	17.5
Анхдагч даралт ихсэх, I10	35.4	36.7	36.2	43.6	7.9	10.7
Зүрхний бусад ишеми, I20.I23-I25	27.8	24.1	25.4	22.4	16.5	18.6
Тархины судасны бусад, I64-69	9.5	3.9	5.9	18.7	22.0	20.8
Зүрхний хэм алдагдал ба дамжуулагчийн эмгэгүүд, I44-I49	1.1	0.4	0.6	7.0	7.6	7.4

6.1.4 ШЭЭС БЭЛГИЙН ТОГТОЛЦООНЫ ӨВЧЛӨЛ


Улаанбаатарын хэмжээнд 10 000 хүн амд ногдох шээс бэлгийн тогтолцооны өвчлөл 1001.6 болж нийт өвчлөлийн 10.0 хувийг эзэлж байгаа ба сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 217.4-аар, өмнөх онтой харьцуулахад 130.7-оор тус тус нэмэгдсэн байна.

Зураг 6.8 Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл 10 000 хүн амд, хүйс, дүүргээр 2023 он



10 000 хүн амд шээс бэлгийн тогтолцооны өвчлөлийн түвшнийг хүйсээр харуулбал, Баянгол дүүрэгт эрэгтэй 143.7, Сонгинохайрхан дүүрэгт эрэгтэй 82.5, Сүхбаатар дүүрэгт 94.9, Налайх дүүрэгт эрэгтэй 224.7, Багахангай дүүрэгт эрэгтэй 209.2-оор улаанбаатрын дундажаас их байгаа бол эмэгтэй хүйсийн хувьд Сонгинохайрхан дүүрэгт эмэгтэй 456.0, Сүхбаатар дүүрэгт эмэгтэй 251.8, Налайх дүүрэгт эмэгтэй 1355.3, Багахангай дүүрэгт эмэгтэй 724.7-оор тус тус улаанбаатрын дундажаас их байна.

Зураг 6.9 Шээс бэлгэсийн тогтолцооны өвчлөл насны бүлгээр, 10 000 хүнд ногдох 2023 он



Шээс бэлгийн тогтолцооны өвчлөлийн түвшнийг насны бүлгээр Улаанбаатар хот, улсын хэмжээтэй харьцуулахад 65-аас дээш насанд 3019.1 хамгийн их буюу улсын хэмжээнээс 563.2-оор их байна.

Хүснэгт 6.5. Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл тэргүүлэх шалтгаан дүнд эзлэх хувиар 2014, 2023 он

Тэргүүлэх өвчлөлүүд	2014 он			2023 он		
	эрэгтэй	эмэгтэй	бүгд	эрэгтэй	эмэгтэй	бүгд
Бөөрний сувганцрын өвчнүүд, N10-N16	9.0	32.6	41.5	22.9	23.2	30.1
Эмэгтэй аарцгийн эрхтний үрэвсэл, N70-N77	0.0	19.0	19.0	0.0	17.6	17.6
Эм бэлэг эрхтний үрэвсэлт бус өвчин, N80-98	0.0	10.5	10.5	0.0	10.6	10.6
Түүдгэнцрийн өвчнүүд, N00-N08	3.6	9.0	12.6	1.1	1.4	2.5
Хөхний өвчин, N60-N64	0.2	6.0	6.2	0.2	5.9	6.0
Цистит, N30	0.2	1.7	1.9	0.4	3.1	3.5
Эр бэлэг эрхтний өвчин, N40-N51	3.7	0.0	3.7	9.2	0.0	9.2
Шээс чулуужих өвчин, N20-N23	0.4	0.5	0.8	1.1	1.4	2.5
Бөөрний дутмагшил, N17-N19	1.2	0.7	1.8	2.2	2.1	4.3


Шээс бэлгийн тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 2023 онд бөөрний сувганцрын өвчнүүд 30.1 хувьтай тэргүүлж байгаа бол эмэгтэй аарцгийн эрхтний үрэвсэлт өвчин 17.6, эр бэлэг эрхтний бусад өвчин 9.2, эм бэлэг эрхтний үрэвсэлт бус өвчин 10.6, бөөрний дутмагшил 4.3, түүдгэнцрийн өвчнүүд 2.5, шээс чулуужих өвчин 2.5, цистит 3.5 хувийг тус тус эзэлж байна.

2023 оны байдлаар бөөрний сувганцрын өвчнүүдийг 2013 онтой харьцуулахад 11.4, эмэгтэй аарцгийн эрхтний үрэвсэлт өвчин 1.4, түүдгэнцрийн өвчнүүд 10.1, хөхний өвчин 0.2 хувиар буурсан бол эм бэлэг эрхтний үрэвсэлт бус өвчин 0.1, цистит 1.8, эр бэлэг эрхтний бусад өвчин 5.5, шээс чулуужих өвчин 1.7, бөөрний дутмагшил 2.5 хувиар нэмэгдсэн байна.


6.1.5 ОСОЛ ГЭМТЭЛ БА ЗАРИМ ГАДНЫ ШАЛТГААНЫ ҮР ДАГАВАР

Монгол улсын хэмжээнд 2023 онд 210763 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдсэн бол Улаанбаатарт 1171947 шинэ тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд ногдох осол гэмтлийн тохиолдол 1062.3 болж нийт өвчлөлийн 10.6 хувийг эзэлж байгаа ба сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 204.2-оор, өмнөх онтой харьцуулахад 74.4-оор тус тус нэмэгдсэн байна.

Зураг 6.10 Осол гэмтлийн шалтгаант өвчлөл хүйсээр 2023 он




Зураг 6.11 Осол гэмтлийн шалтгаант өвчлөл 10 000 хүн амд, хүйс, дүүргээр 2023 он



Осол гэмтлийн түвшин хүйсийн хувьд эрэгтэй, эмэгтэйд 10 000 хүнд ногдох осол гэмтэл Баянгол дүүрэгт хамгийн өндөр байна.

Зураг 6.12 Осол гэмтлийн шалтгаант өвчлөл насны бүлгээр,хүйсээр, 10 000 хүнд амд 2023 он




10 000 хүн амд ногдох осол гэмтлийн түвшин 5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлийн түвшин өндөр харин 30 наснаас хойш буурсан байна. Хүйсийн хувьд эрэгтэйд 10 000 хүнд ногдох осол гэмтэл 20-24 насанд хамгийн өндөр байгаа бол эмэгтэйд 0-4 насанд хамгийн өндөр байна.

Осол гэмтлийн шинэ тохиолдлын тэргүүлэх 5 шалтгаан:

№	Шалтгаан	Хувь	10000 хүн амд
1	Уналт W00-W19	48.7	611.6
2	Амьгүй механик хүчинд өртөх W20-W49	15.0	189.1
3	Зам тээврийн осол V00-V99	7.8	98.1
4	Амьтай механик хүчинд өртөх W50-W64	7.9	98.7
5	Хүчирхийлэл X85-Y09	6.9	87.3


Зураг 6.13 Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан дүнд эзлэх хувиар, 2023 он



2023 онд эрэгтэйчүүдийн гэмтлийн 22.8 хувь, эмэгтэйчүүдийн гэмтлийн 17.6 хувийг толгойн гэмтэл


эзэлж нэгдүгээрт орж байна. Эрэгтэйчүүдэд бугуй ба сарвууны гэмтэл 14.8 хувь, 11.1 тохой ба шууны гэмтэл 13.3 хувь, эмэгтэйчүүдэд тохой ба шууны гэмтэл 16.6 хувь, шагай ба тавхайн гэмтэл 14.9 хувийг эзэлж тэргүүлж байна.

Зураг 6.14 Осол гэмтлийн шалтгаант өвчлөл бүргэгдсэн сараар, хувиар



Осол гэмтлийн шинэ тохиодлын 25.4% хавар, 28.2% зун, 25.8% намар, 20.6% өвөл бүртгэгдсэн байна.

Зураг 6.14 Осол гэмтэлд өртсөн байршил, хувиар 2023 он



Осолд гэмтэлд өртсөн нийт тохиолдлыг байршлаар харуулбал 35.3% гэртээ, 30% гудамж замд гэмтсэн байна.Осолд гэмтэлд өртсөн хүмүүсийн 95.0 хувь нь эрүүл мэндийн байгууллагад өөрөө ирж тусламж авсан ба 4.7 хувь нь түргэн тусламжаар, 0.3 хувь нь бусад хэлбэрээр эмнэлэгт ирж тусламж үйлчилгээ авсан байна.

УНАЛТЫН ШАЛТГААНТ ОСОЛ ГЭМТЛИЙН ШИНЭ ТОХИОЛДОЛ /W00-W19/

Улсын хэмжээнд 2023 онд уналтын шалтгаант 94550 шинэ тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 279.5 байгаа нь өмнөх оноос 24.1-ээр нэмэгдсэн байна. Унаж гэмтсэний улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийн 53.7%-ийг эрэгтэйчүүд, 46.3%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.


Улаанбаатар хотод уналтын шалтгаант 75860 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 462.3 байгаа нь өмнөх оноос 35.8-аар нэмэгдсэн байна. Нийт тохиолдлын 53% нь эрэгтэйчүүд, 47% нь эмэгтэйчүүд байна. Унаж гэмтсэн хүмүүсийн хамгийн их хувь нь шагай ба тавхайн гэмтэл /21.8%/, тохой ба шууны гэмтэл /18.1%/ байна. Осол гарах үеийн байршлаар авч үзвэл гэртээ 36.2%, гудамж замд 29.0%, биеийн тамир спортын талбайд 13.3%, сургууль цэцэрлэгт 7.4% гэмтсэн байна. Уналтын шалтгаант өвчлөлийг насны бүлгээр авч үзэхэд тохиолдлын тоогоор хамгийн их буюу 0-4 насны хүүхэд 13.1%, 5-9 насны хүүхэд 10.7%, 10-14 насны хүүхэд 13.2%-ыг эзэлж байна.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /V01-V99/

Улсын хэмжээнд 2023 онд зам тээврийн осолд өртсөний улмаас 23548 хүн эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авсан нь 10000 хүн амд 69.6 байна. Зам тээврийн осолд өртсөн иргэдийн 64.6% нь эрэгтэйчүүд, 35.4% нь эмэгтэйчүүд байна.

Улаанбаатар хотод зам тээврийн осол гэмтлийн 15903 шинэ тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 96.9 байна. Нийт бүртгэгдсэн тохиолдлыг хүйсээр авч үзвэл 60.4% нь эрэгтэй, 39.6% нь эмэгтэй байна.

Зураг 6.14 Зам тээврийн ослын шалтгаант өвчлөлийн тохиолдлын тоо, насны бүлэг, хүйсээр 2023 он



Зам тээврийн осолд өртөх тохиолдол эрэгтэйд 10-14 насанд, эмэгтэйд 20-24 насанд хамгийн их байна. Нийт тохиолдлын 5.8% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртсөн байна. Ачааны машинтай явж байгаад гэмтсэн тохиолдлын 25.8%, суудлын машинтай явж байгаад гэмтсэн тохиолдлын 24.4% нь гэмтэл авах үедээ хамгаалах суудлын бүс хэрэглээгүй байна.

6.2.1 ХҮҮХЭД ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ӨВЧЛӨЛ

Улаанбаатар хотод 0-19 насны хүүхдийн нийт 526977 өвчлөл амбулаторт бүртгэгдсэн нь өмнөх оноос 83334-өөр нэмэгдсэн байна. Нийт өвчлөлөөс УБ хотын харъяаллын хүүхдийн өвчлөл 464134 тохиолдол бүртгэгдсэн нь бүртгэгдсэн өвчлөлийн 88.1 хувийг эзэлж байна.

Хүүхдийн өвчлөлийн насны бүтцийг авч үзэхэд 0-1хүртэлх насанд 13.9%(73644), 1-4 насанд 26.1% (137626), 5-9 насанд 24.8% (130627), 10-14 насанд 20.1% (106082), 15-19 насанд 14.9% (78998) хувийг тус тус эзэлж байна.

0-1 хүртлэх насны хүүхдийн тэргүүлэх шалтгаант өвчлөл:

1. Амьсгалын тогтолцооны өвчлөл 27.3%
2. Төрөх үед үүссэн зарим эмгэг 16.7%
3. Мэдрэлийн тогтолцооны өвчлөл 11.8%
4. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин 8.2%
5. Хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчлөл 7.1

1-4 насны хүүхдийн тэргүүлэх шалтгаант өвчлөл:

1. Амьсгалын тогтолцооны өвчлөл 41.8%
2. Осол гэмтэл, бэртэл хордлого, гаднын шалтгаан өвчлөл 15.3%
3. Хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчлөл 11.1%
4. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин 9.3%
5. Чих ба хөхөнцрийн өвчлөл 3.6%

5-9 насны хүүхдийн тэргүүлэх шалтгаант өвчлөл:

1. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 24.7%
2. Амьсгалын тогтолцооны өвчлөл 24.7%
3. Осол гэмтэл, бэртэл хордлого, гаднын шалтгаан өвчлөл 14.1%
4. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин 8.9%
5. Нүд ба түүний дайврын өвчин 4.9%


10-14 насны хүүхдийн тэргүүлэх шалтгаант өвчлөл:

1. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 21.9%
2. Амьсгалын тогтолцооны өвчлөл 16.4%
3. Осол гэмтэл, бэртэл хордлого, гаднын шалтгаан өвчлөл 21.9%
4. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин 10.7%
5. Нүд ба түүний дайврын өвчин 5.1%

15-19 насны хүүхдийн тэргүүлэх шалтгаант өвчлөл:

1. Осол гэмтэл, бэртэл хордлого, гаднын шалтгаан өвчлөл 22.0%
2. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 18.6%
3. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин 12.9%
4. Амьсгалын тогтолцооны өвчлөл 13.8%
5. Шээс бэлгэсийн тогтолцооны өвчлөл 8.3% хувийг тус тус эзэлж байна.

Тав хүртэлх насны хүүхдийн амьсгалын тогтолцооны өвчлөлийн шалтгаан, хувиар




Тав хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, тухайн насны 1000 хүүхдэд, 2019-2023 он

Шалтгаан	Улаанбаатар				
	2019	2020	2021	2022	2023
Амьсгалын замын тогтолцооны өвчин	300.7	160.5	106.1	353.3	507.1
Осол гэмтлийн шалтгаант өвчин	53.7	37.7	24.3	114.6	156.4
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	91.8	80.8	85.6	92.8	133.9
Арьс ба халимны өвчин	111.5	96.0	69.7	87.3	123.0
Чих ба хөхөнцрийн өвчин	53.7	37.7	24.3	41.9	59.9
Нүд ба түүний дайврын өвчин	48.9	40.8	42.2	38.7	61.4

Хүүхэд, өсвөр насны өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, тухайн насны 1000хүүхдэд, 2020-2023 он


Шалтгаан	5-9 нас			10-14 нас			15-19 нас		
	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	105.4	134.4	165.0	89.4	109.6	135.2	110.0	117.3	136.2
Осол гэмтлийн шалтгаант өвчин	53.7	75.6	94.2	58.9	115.8	135.5	94.9	124.0	161.0
Амьсгалын замын тогтолцооны өвчин	44.0	128.8	164.6	40.5	79.0	101.1	54.9	73.2	101.1
Арьс ба халимны өвчин	35.1	46.6	59.7	45.2	59.2	66.5	74.7	82.7	94.6
Чих ба хөхөнцрийн өвчин	13.6	18.5	23.9	12.0	14.0	16.4	12.1	10.0	14.4
Мэдрэлийн тогтолцооны өвчин	11.7	14.2	26.2	14.8	22.0	32.7	22.4	29.0	42.9
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	19.8	28.2	34.8	18.0	27.8	34.0	31.0	41.1	60.9
Нүд ба түүний дайврын өвчин	20.7	25.2	34.2	19.4	25.4	30.3	18.8	19.5	23.9




6.3.1 ХОРТ ХАВДАР

Монгол улсын хүн амын дунд 2023 онд 7244 хорт хавдрын шинэ тохиолдол, Улаанбаатар хотод 3386 хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдэж 100000 хүн амд 206.3 байна. Хүйсийн хувьд эрэгтэй 1680, эмэгтэй 1706 тохиолдол бүртгэгдсэн байна. Зонхилон тохиолдох хорт хавдрын өвчлөлийн бүтцэд элэгний хорт хавдар 31.3%, ходоодны хорт хавдар 16.5%, уушгины хорт хавдар 6.1%, улаан хоолой 3.9%, умайн хүзүүний хорт хавдар 5.6%, хөхний өмөн 6.8% эзэлж байна.


Шинээр бүртгэгдсэн хорт хавдрын өвчлөл, 100000 хүн амд, 2013-2023 он



Зураг 6.14 Зонхилон тохиолдох хорт хавдрын байрлал, эзлэх хувиар, эрэгтэй 2023 он



Зураг 6.14 Зонхилон тохиолдох хорт хавдрын байрлал, эзлэх хувиар, эмэгтэй 2023 он



ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛИЙН 5 ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН, FIVE LEADING CAUSES OF CANCER

Өвчний ангилал / Он		2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Элэг – C22	Бодит тоо	360	298	668	674	778	700	924	813	945	1063
	10000 хүн амд	2.9	2.3	5	4.9	5.4	4.9	6.2	5.3	6	6.6
Ходоод - C16	Бодит тоо	237	186	351	340	369	414	475	363	557	557
	10000 хүн амд	18.4	14	25.7	24.3	2.58	2.84	3.2	2.35	3.55	3.4
Умайн хүзүү-C53	Бодит тоо	161	145	240	166	161	133	254	135	141	190
	10000 хүн амд	1.3	1.1	1.8	1.2	1.2	0.9	1.7	0.9	0.9	1.2
Уушги- C34	Бодит тоо	140	79	118	148	189	177	191	173	207	208
	10000 хүн амд	1.1	0.6	0.9	1.1	1.4	1.2	1.3	1.1	1.3	1.3
Хөх- C50	Бодит тоо	71	62	139	158	136	137	140	164	173	231
	10000 хүн амд	0.6	0.5	1	1.2	1	1	0.9	1.1	1.1	1.4

Хүснэгт 6.7 Улаанбаатарт шинээр бүртгэгдсэн хорт хавдрын нийт өвчлөл, 10 000 хүн амд өвчний ангилал, дүүргээр 2023 он

№	Дүүрэг	Үзүүлэлт	Уруул, амны хөндий, залгиурын	Хоол боловсруулах эрхтний	Амьсгалын ба цээжний хөндийн	Яс ба үений мөгөөрсний	Арьсны меленом ба бусад	Мезотел ба зөөлөн эдийн	Хөхний өмөн	Эм бэлэг эрхтний өмөн	Эр бэлэг эрхтний өмөн	Шээсний замын өмөн	Нүд, тархи ба төв мэдрэлийн тогтолцооны бусад хэсгийн	Бамбай булчирхай ба бусад дотоод шүүрлийн	Тодорхойгүй, хоёрдогч байршил нь заагдаагүй	Тунгалагийн цус төлжүүлэх ба тэдгээрийн төрлийн эдийн	Нийт
1	Баянгол	Бодит тоо	4	264	24	3	2	6	39	47	3	13	10	13	1	10	439
		10000 х/а	0.2	10.6	1.0	0.1	0.1	0.2	1.6	1.9	0.1	0.5	0.4	0.5	0.0	0.4	17.6
2	Баянзүрх	Бодит тоо	7	336	48	5	1	4	34	38	7	35	16	9	3	17	560
		10000 х/а	0.2	7.9	1.1	0.1	0.0	0.1	0.8	0.9	0.2	0.8	0.4	0.2	0.1	0.4	13.2
3	Сонгино хайрхан	Бодит тоо	10	417	58	4	2	4	25	42	3	30	16	9	6	19	645
		10000 х/а	0.3	12.2	1.7	0.1	0.1	0.1	0.7	1.2	0.1	0.9	0.5	0.3	0.2	0.6	18.9
4	Сүхбаатар	Бодит тоо	6	182	13	0	1	1	23	28	1	13	3	6	2	13	292
		10000 х/а	0.4	12.8	0.9	0.0	0.1	0.1	1.6	2.0	0.1	0.9	0.2	0.4	0.1	0.9	20.6
5	Хан-Уул	Бодит тоо	12	330	41	3	6	9	40	69	3	41	11	22	5	13	605
		10000 х/а	0.5	13.3	1.7	0.1	0.2	0.4	1.6	2.8	0.1	1.7	0.4	0.9	0.2	0.5	24.4
6	Чингэлтэй	Бодит тоо	1	106	17	1	1	1	15	8	0	6	6	1	1	10	174
		10000 х/а	0.1	7.6	1.2	0.1	0.1	0.1	1.1	0.6	0.0	0.4	0.4	0.1	0.1	0.7	12.4
7	Налайх	Бодит тоо	0	56	7	0	1	0	3	7	1	3	2	0	0	2	82
		10000 х/а	0.0	14.0	1.8	0.0	0.3	0.0	0.8	1.8	0.3	0.8	0.5	0.0	0.0	0.5	20.5
8	Багануур	Бодит тоо	1	27	2	0	0	0	0	1	0	0	2	1	0	1	35
		10000 х/а	0.3	9.3	0.7	0.0	0.0	0.0	0.0	0.3	0.0	0.0	0.7	0.3	0.0	0.3	12.0
9	Багахангай	Бодит тоо	0	2	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	4
		10000 х/а	0	4.53	0	0	0	0	2.26	2.26	0	0	0	0	0	0	9.1
10	Бүгд	Бодит тоо	41	1664	203	16	13	25	177	234	17	138	64	61	18	83	2754
		10000 х/а	0.3	10.3	1.3	0.1	0.1	0.2	1.1	1.4	0.1	0.9	0.4	0.4	0.1	0.5	17.0

6.3.2 ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДАР


Монгол улсад 2023 онд 0-19 насанд 125 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдсэн бол Улаанбаатар хотод 100 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдсэн байна. Үүний 60% (60) хөвгүүд, 40% (40) охид байна. 0-19 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн бүтцэд лейкоми тэргүүлж байгаа ба тархи мэдрэлийн, яс мөгөөрсний, миелома, элэг, ходжкины бус лимфома хавдар орж байна.

Зураг 6.16 Хүүхдийн хорт хавдрын бүтэц, хувиар, 0-1 нас




2023 онд 0-1 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн 13 тохиолдол бүртгэгдэж, шинээр бүртгэгдсэн хорт хавдрын нийт тохиолдлын 69.2 хувь нь эрэгтэй, 30.8 хувь нь эмэгтэй байна.

Зураг 6.17 Хүүхдийн хорт хавдрын бүтэц, хувиар 1-4 нас




2023 онд 1-4 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн 29 тохиолдол бүртгэгдсэнээс лейкоми 48.3 хувьтай тэргүүлж байна. 1-4 насанд шинээр бүртгэгдсэн хорт хавдрын нийт тохиолдлын 48.3 хувь нь эрэгтэй, 51.7 хувь нь эмэгтэй байна.

Зураг 6.18 Хүүхдийн хорт хавдрын бүтэц, хувиар 5-9 нас




2023 онд 5-9 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн 25 тохиолдол бүртгэгдсэнээс Лимфобластын цочмог лейкоз 48.0 хувьтай тэргүүлж байна. 5-9 насанд шинээр бүртгэгдсэн хорт хавдрын нийт тохиолдлын 64.0 хувь нь эрэгтэй, 36.0 хувь нь эмэгтэй байна.

Зураг 6.19 Хүүхдийн хорт хавдрын бүтэц, хувиар 10-14 нас



2023 онд 10-14 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн 14 тохиолдол бүртгэгдсэнээс цочмог миелолейкоз 50 хувьтай тэргүүлж байна. 10-14 насанд шинээр бүртгэгдсэн хорт хавдрын нийт тохиолдлын 71.4 хувь нь эрэгтэй, 28.6 хувь нь эмэгтэй байна.

Зураг 6.20 Хүүхдийн хорт хавдрын бүтэц, хувиар 15-19 нас



2023 онд 15-19 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн 19 тохиолдол бүртгэгдсэнээс лимфобластын цочмог лейкоз 26.3 хувьтай тэргүүлж байна. 15-19 насанд шинээр бүртгэгдсэн хорт хавдрын нийт тохиолдлын 35 хувь нь эрэгтэй, 65 хувь нь эмэгтэй байна.

6.4. ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ

Улаанбаатар хотод эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 2023 онд хамрагдвал зохих хүн амын 44.5 хувь буюу 681031 хүн хамрагдсан байна. Хамрагдсан хувийг авч үзэхэд Багануур 57.4%, Налайх -56.2%, Багахангай -52.1%, Сүхбаатар -50.0% буюу хамгийн сайн хамрагдалттай бол Сонгинохайрхан -24.1% буюу хамгийн сул хамрагдалтай байна.

Эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамрагдсан байдал:

№	Дүүргийн нэр	Хамрагдвал зохих хүний тоо	Хамрагдсан хүний тоо	Хамрагдалтын хувь
1.	Багануур	236835	135937	57.4
2.	Багахангай	383892	199899	52.1
3.	Баянгол	29343	10385	38.3
4.	Баянзүрх	4463	2021	45.3
5.	Чингэлтэй	38797	17066	43.9
6.	Сүхбаатар	142444	71243	50.0
7.	Сонгинохайрхан	341450	82313	24.1
8.	Налайх	209524	117749	56.2
9.	Хан-Уул	144172	44418	30.8
10	Нийт	1530920	681031	44.5

Улсын хэмжээнд артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 1317011 хүн хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 61.9 хувийг эзэлж байна. Хамрагдалтыг өмнөх онтой харьцуулахад бодит тоогоор 155359 хүнээр нэмэгдсэн байна. Үр дүнгийн үзүүлэлтээр онош батлагдсан 1.1 буюу өмнөх онтой харьцуулахад 0.3% хувь буурсан байна. Улаанбаатар хотод артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 682746 хүн хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 67.7 хувийг хамруулсан эзэлж байна. Хамрагдалтыг өмнөх онтой харьцуулахад бодит тоогоор 85136 хүнээр нэмэгдсэн байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 1.1 хувьд нь артерийн гипертензи оношлогдсон буюу өмнөх онтой харьцуулахад 0.2 хувиар өссөн байна.

Улсын хэмжээнд чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 35-аас дээш насны нийт 1031744 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 79.1 хувийг эзэлж байна. Хамрагдалтыг өмнөх онтой харьцуулахад бодит тоогоор 88730 хүнээр нэмэгдсэн байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.3 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна. Улаанбаатар хотод чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 566635 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 90.7 хувийг эзэлж байна. Хамрагдалтыг өмнөх онтой харьцуулахад бодит тоогоор 63917 хүнээр нэмэгдсэн байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувьд нь чихрийн шижин өвчин оношлогдсон байна.

Улаанбаатар хотод элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 80935 хүн хамрагдсан нь өмнөх онтой харьцуулахад бодит тоогоор 31222 хүнээр нэмэгдсэн байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 43 тохиолдол буюу 0.05 хувьд хавдар оношлогдсон байна.

Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь, 2023 он

Үзүүлэлт		БГДЭМТ	БЗДЭМТ	СХДЭМТ	СБДЭМТ	ХУДЭМТ	ЧДЭМТ	НДЭМТ	БНДЭМТ	БХДЭМТ	Тосгоны ЭМТ-үүд	Дүн
Хамрагдах хүн амын тоо		155743	251871	215190	92523	146075	93309	24774	18879	2816	14761	1007929
Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо		116314	153869	108649	86782	121718	49778	22148	12597	2099	8792	682746
	Эрэгтэй	42838	52823	41720	30957	47604	17805	10445	5314	971	3560	254037
	Эмэгтэй	73476	101046	66929	55825	74114	31973	11703	7283	1128	5232	428709
Хамрагдалтын хувь		74.7	61.1	50.1	93.8	83.3	53.3	89.4	66.7	74.5	225.6	67.7
Давтан үзлэг		11200	51622	5032	14165	36678	8358	5378	670	1669	1915	136687
Оношлогдсон артерийн гипертензи		663	2443	870	1736	249	0	321	53	0	842	7177
Хамрагдах хүн амын тоо		98157	152027	126174	59406	89860	59125	15239	11689	1674	11517	624868
Чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо		87073	139458	82120	83324	93829	40247	18468	12070	1919	8127	566635
	Эрэгтэй	31466	47594	31541	31269	36746	13965	8471	5108	879	3229	210268
	Эмэгтэй	55607	91864	50579	52055	57083	26282	9997	6962	1040	4898	356367
Хамрагдалтын хувь		88.7	91.7	65.1	140.3	104	68.1	121.2	103.2	114.6	287	90.7
Давтан үзлэг		2089	33442	2275	6769	13133	3358	2846	207	1486	1390	66995
Оношлогдсон чихрийн шижин		106	640	226	301	44	0	18	8	0	43	1386
Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо		4212	20840	15864	653	26652	7922	173	1836	1037	1746	80935
	Эрэгтэй	1388	7198	5975	262	9429	2672	116	800	457	918	29215
	Эмэгтэй	2824	13642	9889	391	17223	5250	57	1036	580	828	51720
Оношлогдсон Хорт хавдар		0	8	9	16	3	0	7	0	0	0	43

Умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэг

Улсын хэмжээнд 2023 оны 1-12 сарын байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан эрт илрүүлэгт зорилтот насны нийт 91533 (37.8%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 3.8 хувь нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй. Үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн тохиолдол 56 бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотод умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт зорилтот насны 36710 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 30.1 хувийг эзэлж байна. Хамрагдалтыг өмнөх онтой харьцуулахад бодит тоогоор 4431 хүнээр нэмэгдсэн ба эсийн шинжилгээ эерэг 642 буюу 2.0% тохиолдол бүртгэгдсэн байна.

Хөхний хорт хавдрын боломжит илрүүлэгт 513394 эмэгтэй хамрагдсанаас 2066 (0.4%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг, хорт хавдрын шинэ өвчлөлийн тохиолдол 3 бүртгэгдсэн байна. Хамрагдалтыг өмнөх онтой харьцуулахад бодит тоогоор 55670 хүнээр нэмэгдсэн. Улаанбаатар хотод хөхний хорт хавдарын эрт илрүүлэгт 224606 эмэгтэй хамрагдсан байна. Хамрагдалтыг өмнөх онтой харьцуулахад бодит тоогоор 23182 хүнээр нэмэгдсэн ба хөхний эмнэлзүйн шинжилгээгээр эерэг гарсан 573 буюу 0.3% тохиолдол бүртгэгдсэн байна.


Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь, 2023 он

№	Аймаг, дүүргийн нэр	Умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг							Хөхний хорт хавдрын илрүүлэг			
		Зорилтот бус насны бүлгийн хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	Зорилтот насны хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	Хорт хавдар илэрсэн шинэ тохиолдлын тоо	Зорилтот насны бүлгийн эмэгтэйчүүдийн илрүүлэг үзлэгт хамрагдсан хувь	Эсийн шинжилгээний наацын тоо	Эсийн шинжилгээ эерэг гарсан тохиолдлын тоо	Эерэг гарсан эсийн шинжилгээний эзлэх хувь	Илрүүлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	Хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг гарсан эмэгтэйчүүдийн тоо	ХЭҮ-ийн эерэг гарсан хувь	Хорт хавдар илэрсэн шинэ тохиолдлын тоо
1	Баянгол	652	4447	3	22.3	5707	14	0.2	34639	123	0.4	0
2	Баянзүрх	918	9348	4	29.7	8843	263	3.0	86519	365	0.4	0
3	Сонгинохайрхан	152	3400	0	13.6	514	18	3.5	4869	0	0.0	0
4	Сүхбаатар	150	6904	2	64.1	3875	48	1.2	25384	0	0.0	0
5	Хан-Уул	1975	5739	15	30.5	7639	169	2.2	55785	39	0.1	0
6	Чингэлтэй	264	4412	0	40.9	4570	99	0.0	6385	1	0.0	0
7	Налайх	220	1210	0	44.8	0	0	0.0	4683	0	0.0	0
8	Багануур	0	1108	0	51.5	1070	31	2.9	5859	45	0.8	0
9	Багахангай	3	142	0	47.5	0	0	0.0	483	0	0.0	0
Улаанбаатар дүн		4334	36710	24	30.1	32218	642	2.0	224606	573	0.3	0
Аймгийн дүн		7864	54823	32	45.7	54022	2657	4.9	288788	1493	0.5	3
Улсын дүн		12198	91533	56	37.8	86240	3299	3.8	513394	2066	0.4	3

6.5. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

Улсын хэмжээнд сэтгэц ба зан төрхийн эмгэг амбулаторт 35815 өвчлөл бүртгэгдсэн ба 10000 хүн амд 105.9, стационарт хэвтэн эмчлүүлэгчид 27401 өвчлөл буюу 10000 хүн амд 80.9 тохиолдол бүртгэгдсэн байна. Улаанбаатарт 16079 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 99.3 байна.

Сэтгэц болон зан төрхийн эмгэгийн өвчлөл, дүүргээр, 10000 хүн амд




Сэтгэцийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан 10000 хүн амд харьцуулснаар:

- Сэтгэцийн ба зан үйлийн бусад өвчнүүд /F50-F69, F80-F99/ 4785 тохиолдол буюу 10000 хүн амд 29.6
- Неврозууд ба сэтгэлийн шалтгаант бие мах бодын эмгэгүүд /F40-F49/ 3275 тохиолдол буюу 10000 хүн амд 20.2
- Сэтгэцийн органик ба шинж тэмдгийн эмгэг /F00-F09/ 2974 буюу 10000 хүн амд 18.4
- Сэтгэцийн нөлөөт эмийн бодисын шалтгаант сэтгэцийн ба аягийн эмгэг /F10-F19/ 2288 тохиолдол буюу 10000 хүн амд 14.1
- Сэтгэцийн хөгжлийн саатал /F70-F79/ 2142 тохиолдол буюу 10000 хүн амд 13.2
- Шикофрени, шизо хэв шинжит ба дэмийрэх эмгэг /F20-F29/ 376 тохиолдол буюу 10000 хүн амд 2.3
- Сэтгэл хөдлөлийн эмгэгүүд /F30-F39/ 239 тохиолдол буюу 10000 хүн амд 1.5 байна.

Сэтгэцийн ба зан үйлийн бусад эмгэгийн 28.9 хувийг 1-4 насны хүүхэд, 24.3 хувийг 5-9 насны хүүхэд, 10.8 хувийг 10-14 насны хүүхэд, 8.1 хувийг 15-19 насны хүүхэд эзэлж байгаа бөгөөд 72.1 хувь нь 1-19 насны хүүхэд байна. Сэтгэц хөгжлийн саатал эмгэгийн 13.4 хувийг 35-39 нас, 10.9 хувийг 30-34 нас, 10.6 хувийг 40-44 нас, 9.4 хувийг 25-29 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд 44.3 хувийг 25-44 насны иргэд эзэлж байна. Неврозын ба сэтгэлийн шалтгаант бие мах бодын эмгэгийн 15.8 хувийг 35-39 нас, 13.9 хувийг 30-34 нас, 12.1 хувийг 40-44 нас, 11.1 хувийг 45-49 нас, 9.7 хувийг 50-54 нас эзэлж байгаа бөгөөд 62.6 хувийг 30-54 насны иргэд эзэлж байна. Сэтгэцийн органик ба шинж тэмдгийн эмгэгийн 12.1 хувийг 55-59 нас, 10.1 хувийг 50-54 нас, 7.4 хувийг 45-49 нас, 13.3 хувийг 60-64 нас эзэлж байгаа бөгөөд 42.9 хувийг 45-64 насны иргэд эзэлж байна.


Сэтгэц болон зан төрхийн эмгэгийн өвчлөл, дүүргээр, 10000 хүн амд, 2023 он



6.6. ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ӨВЧЛӨЛ

Улсын хэмжээнд хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөлийн 1046574 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 3082.8, Улаанбаатар хотод 580820 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 3588.3 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 29.4-өөр нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн тохиолдлын 460309 нь улаанбаатрын хаягтай иргэд бөгөөд 10000 хүн амд 2843.9 байна.

Хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд, 2023 он



Хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, дүүргээр, 10000 хүн амд, 2023 он

Өвчлөл	БГД	БЗД	СХД	СБД	ХУД	ЧД	Налайх	Багануур	Багахангай
Амьсгалын тогтолцооны өвчин	451.7	517.0	564.3	628.8	619.7	520.2	523.9	747.2	708.3
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	324.3	277.4	308.2	414.4	328.0	323.4	331.5	493.9	497.9
Хоол боловсруулах эрхтний өвчин	335.3	330.4	398.7	382.5	313.2	332.6	294.2	459.6	330.4
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	186.7	179.7	175.0	253.3	250.8	200.3	185.4	224.1	294.2
Мэдрэлийн тогтолцооны өвчин	208.7	150.8	159.6	209.9	194.9	174.3	139.1	225.9	296.4


Хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, 10000 хүн амд, УБ, 2018-2022 он
Leading causes of inpatient morbidity, per 10000 population, Ulaanbaatar, 2018-2022

Тэргүүлэх шалтгаан /Leading causes	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Амьсгалын тогтолцооны өвчин /Diseases of the respiratory system	504.5	277.6	165	522.2	547.6
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин /Diseases of the circulatory system	376.1	303.5	236.2	305.2	320.7
Хоол боловсруулах эрхтний өвчин /Diseases of the digestive system	363.3	350.4	303.2	345.5	349.1
Шээс бэлгийн тогтолцооны өвчин /Diseases of the genito-urinary system	265.7	249.4	208.1	227.7	200.2
Мэдрэлийн тогтолцооны өвчин /Diseases of the nervous system	206.9	207.1	132.5	168.3	177.0

Хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж буй амьсгалын тогтолцооны эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны дотор зонхилж буй өвчнүүдийг авч үзвэл:

- Амьсгалын тогтолцооны өвчний дотор уушгины хатгалгааны улмаас хэвтэн эмчлүүлэгчид 42875 тохиолдол буюу 55.0 хувь
- Хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор элэгний эмгэгийн улмаас хэвтэн эмчлүүлэгчид 18817 тохиолдол буюу 26.4 хувь
- Зүрх судасны өвчний дотор цусны даралт ихсэх өвчний улмаас хэвтэн эмчлүүлэгчид 17553 тохиолдол буюу 25.8 хувь
- Шээс бэлгийн тогтолцооны өвчний дотор бөөрний сувганцрын үрэвсэлт өвчний улаас хэвтэн эмчлүүлэгчид 15822 тохиолдол буюу 38.5 хувь
- Мэдрэлийн тогтолцооны өвчний дотор мэдрэлийн ёзоор ба сүлжээний эмгэгийн улмаас хэвтэн эмчлүүлэгч 11669 тохиолдол буюу 32.1 хувийг тус тус эзэлж байна

Хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөл, 10000 хүн амд, 2013-2023 он



Хүн амын өвчлөлийн бүтэц, 2023 он

№	Өвчний ангилал	Хэвтэн эмчлүүлэгсдийн өвчлөл				Амбулаторийн өвчлөл			
		Улс		Улаанбаатар		Улс		Улаанбаатар	
		Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
1	Халдварт өвчин	24390	68.3	9364	57.9		0.0	21292	57.9
2	Хавдар	41847	117.1	19806	122.4	67649	189.3	39139	122.4
3	Цус, цус бүтээх эрхтний өвчин	3780	10.6	1331	8.2	19472	54.5	10374	8.2
4	Дотоод шүүрэл бодисын солилцооны өвчин	21863	61.2	10024	61.9	127287	356.3	65883	61.9
5	Сэтгэцийн ба аягийн эмгэг	27401	76.7	12729	78.6	35815	100.2	13748	78.6
6	Мэдрэлийн тогтолцооны өвчин	70652	208.9	28656	177.0	216176	639.1	88142	177.0
7	Нүд ба түүний дайврын өвчин	14857	43.9	7317	45.2	187715	554.9	74501	45.2
8	Чих ба хөхөнцрийн өвчин	4196	11.74	1704	10.5	102481	286.8	39529	10.5
9	Зүрх судасны тогтолцооны өвчин	135909	401.8	51913	320.7	465748	1376.9	175868	320.7
10	Амьсгалын тогтолцооны өвчин	173638	513.3	88631	547.6	653146	1930.8	224889	547.6
11	Хоол шингээх эрхтний өвчин	115925	342.7	56509	349.1	704652	2083.1	274859	349.1
12	Арьс ба халимны өвчин	24772	73.2	8813	54.4	214835	635.1	106079	54.4
13	Яс булчингийн тогтолцооны өвчин	63869	188.8	23269	143.8	193495	572.0	87822	143.8
14	Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	88054	260.3	32399	200.2	389126	1150.3	162115	200.2
15	Жирэмслэх, төрөх, төрсний дараах үе	118591	331.9	57581	355.8	38666	108.2	24113	355.8
16	Перинаталь үед үүсэх зарим эмгэг	10883	30.5	5500	34.0	18341	51.3	9688	34.0
17	Төрөлхийн гажиг	3821	10.7	1715	10.6	26124	73.1	12437	10.6
19	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	40327	119.2	19011	117.5	258666	764.7	171947	117.5
21	Уламжлалт анагаах ухаанаар оношлогдсон өвчлөл	53196	148.9	20809	128.6	33126	0.0	10875	128.6
22	Бусад өвчлөл	4864	63.1	3228	19.9	56320	332.9	2459	19.9
22	НИЙТ ДҮН	1042835	3082.8	460309	2843.9	3808840	11259.7	1615759	2843.9

БҮЛЭГ VII. ХҮН АМЫН НАС БАРАЛТ

Монгол улсад хүн амын өвчлөл, эндэгдлийн шалтгаанд 1990 оноос өмнө амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 1990 оноос хойш зүрх судасны шалтгаант өвчин тогтмол тэргүүлэн улмаар өсөх хандлагатай болсон. Зүрх судасны өвчний шалтгаант нас баралт 1950-иад онд 7.1 хувь, 1985 онд 23.4 хувь, 1995 оноос 30.8 хувийг эзэлж байсан ба 2023 оны байдлаар 33.0 хувь байна. Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын дийлэнх хувийг артерийн даралт ихсэлт, зүрхний шигдээс, тархины цус харвалт эзэлж байна.

7.1 ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар 17 мянган нас баралтын тохиолдол бүртгэгдсэнээс 60.7 хувь нь эрэгтэйчүүд, 39.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд шалтгаанаар авч үзвэл зүрх судасны тогтолцооны өвчин (33.1%), хавдар (24.5%), осол гэмтэл, гаднын шалтгаан (16.6%) зонхилж байна. Нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувь өссөөр байна. Хүн амын нас баралт 2023 онд 17.5 мянга болж, сүүлийн 10 жилийн дунджаас 457 (2.7%)-ээр хүн нэмэгдэж, өмнөх оноос 448 (2.5%) хүнээр буурсан. Нас баралтын ерөнхий коэффициент 2023 онд 5.2 байгаа бөгөөд 1000 эрэгтэй хүн амд 6.5, эмэгтэй хүн амд 3.9 тус тус байна.


Өвчний ангилал	Улс		Улаанбаатар	
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	5794	17.1	2515	15.5
Хавдар	4330	12.8	2073	12.8
Осол гэмтэл, гаднын шалтгаан	3094	9.1	1864	11.5
Хоол шингээх эрхтний өвчин	1204	3.6	718	4.4
Амьсгалын тогтолцооны өвчин	893	2.6	501	3.1

Улаанбаатар хотод нас баралтын 8928 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 301 тохиолдлоор буюу 3.3 хувиар буурсан байна. Нас барсан хүний 60.8 хувь нь эрэгтэй, 39.2 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 51.5 хувь нь ЭМЯ-ны харьяа улсын болон хувийн хэвшлийн эмнэлэгт, 48.5 хувь нь НЭМГ-т мэдээ өгдөг улсын болон хувийн хэвшлийн эмнэлэгт бүртгэгдсэн байна. Нас баралтын түвшин 1000 хүнд 5.5 байна.




Нас барсан хүний 79.1 хувь нь өвчний улмаас, 20.9 хувь нь осол гэмтлийн улмаас нас барсан байна. Улаанбаатар хотод эмнэлгийн нас баралтын 3724 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 223 тохиолдлоор өссөн байна. Улаанбаатар хотын харьяалалтай иргэдийн нас баралтын 38.3 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж байгаа нь сүүлийн 5 жилийн дунджаас 1.9 хувиар бага байна.

Хүн амны нас баралт, тэргүүлэх шалтгаан, 10000 хүн амд, хүйсээр, 2023 он



Хүн амын нас баралт, насны ангиллаар, хувиар, 2023 он



7.2 ЗҮРХ СУДАСНЫ ТОГТОЛЦООНЫ ӨВЧНИЙ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Зүрх судасны тогтолцооны өвчний улмаас жил бүр 5500-6000 хүн нас барж байгаа бөгөөд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байна. Хүн амын нас баралтын нэгдүгээр шалтгаан болох зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барсан хүмүүсийн 60.0% эрэгтэйчүүд, 40.0% нь эмэгтэйчүүд байна.

Зүрх судасны тогтолцооны өвчнөөс зүрхний ишеми өвчин, тархины цус харвалт, бусад зүрх судасны тогтолцооны өвчин, зүрхний шигдээс дийлэнх хувийг эзэлж байна. Эдгээр нийтлэг өвчин тус бүрд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс харьцангуй их байна.

Нас барсан хүмүүс насны хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү залуу насандаа нас барсан нь эрэгтэйчүүд 45-с дээш настай, эмэгтэйчүүд 60-с дээш настай байгаагаас харагдаж байна. Эрэгтэйчүүдийн 53.1%, эмэгтэйчүүдийн 19.8% нь хөдөлмөр эрхлэх насандаа зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барсан байна. Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 20.9, 10 000 эмэгтэй хүн амд 13.5 ногдож байгаа ба нийт нас баралтын 33.0 хувийг эзэлж байна.

Улаанбаатар хотод 2023 онд цусны эргэлтийн тогтолцооны өвчлөлийн шалтгаант нас

баралт 2515 бүртгэгдсэн буюу 10 000 хүн амд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6-аар буурсан, нийт нас баралтын 28.2 хувийг эзэлж байна. Цусны эргэлтийн тогтолцооны өвчлөлийн нас баралтад тархинд цус харвалт, тархины архаг цус хомсролт өвчин, зүрхний цочмог шигдээс, даралт ихсэх өвчний шалтгаант нас баралт дийлэнх хувийг эзэлж байна.

Тогтвортой хөгжлийн зорилтын халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг хэмжих нэг шалгуур үзүүлэлт нь 30-70 насны хүн амын дунд бүртгэгдсэн 4 гол шалтгаан болох зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралт юм.

Үүнээс 30-70 насны хүн амын дунд бүртгэгдсэн зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт нийт 2492 тохиолдол бүртгэгдэж, тухайн насны 10 000 хүнд харьцуулахад 32.9 байгаа нь Энэ үзүүлэлтийг хүйсээр харьцуулбал эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс 1.5 дахин өндөр бүртгэгдсэн байна.


7.3 ХОРТ ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Хавдраас шалтгаалсан нас баралт 1990 оноос хойш нас баралтын 2 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд нас барагчдыг хүйсээр авч үзэхэд 56.9 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүдээс илүү өвчилж, нас барж байна. Насны хувьд 40-өөс дээш насныхан 95.0 хувийг эзэлж байна. Хавдрын шалтгаант нас баралт 2023 онд нийт нас баралтын 24.7 хувийг эзэлж, нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 14.8, 10 000 эмэгтэй хүн амд 10.9 байна.

Нас баралт хүйсийн Эрүүл мэндийн үзүүлэлт - 2023 175 хувьд 56.9% нь эрэгтэй, 43.1% нь эмэгтэй байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.3 дахин их байна. Хавдрын төрлийн хувьд дийлэнх нь элэг ба элгэн дэх цэсний сувгийн хорт хавдар, ходоодны хорт хавдар болон амьсгуурсны (бронхын) ба уушгины хорт хавдраас болж нас барсан байна.

Улаанбаатар хотод 2023 онд хорт хавдрийн нас баралтын 2073 тохиолдол буюу 10000 хүн амд 12.8 байгаа нь өмнөх оноос 40 тохиолдлоор өссөн ба 10000 хүн амд 0.6-аар буурсан үзүүлэлттэй байна. Нийт нас баралтын 23.2 хувийг эзэлж байна. Нас баралтыг хүйсээр авч үзэхэд 53.9 хувь нь эрэгтэйчүүд, 46.1 нь эмэгтэйчүүд байна.

Хорт хавдрын нас баралт, 10000 хүн амд, 2014-2023 он



Эрэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, уушги, гуурсан хоолой, улаан хоолой, бүдүүн шулуун гэдэс, харин эмэгтэйчүүдийн дунд элэг, ходоод, умайн хүзүү, улаан хоолой, уушги, гуурсан хоолойн хорт хавдрын нас баралт тэргүүлэх 5 шалтгаан болж байна.

Элэгний өвчлөл өндөр байгаа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн элэгний хорт хавдрын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсоор байна.

**Улаанбаатар хотод бүртгэгдсэн хорт хавдрын нас баралт,
өвчний ангиллаар, дүүргээр, 2023 он**

№	Дүүрэг		Уруул, амны хөндий, залгиурын өмөн	Хоол боловсруулах эрхтэний өмөн	Амьсгалын ба цээжний хөндийн эрхтэний өмөн	Яс ба үений мөгөөрсний өмөн	Арьсны меленом ба бусад өмөн	Мезотел ба зөөлөн эдийн өмөн	Хөхний өмөн	Эм бэлэг эрхтэний өмөн
1	Баянгол	Бодит тоо	4	173	17	1	0	2	5	18
		10000 хүн амд	0.16	6.92	0.68	0.04	0.00	0.08	0.20	0.72
2	Баянзүрх	Бодит тоо	3	269	43	6	0	2	14	18
		10000 хүн амд	0.07	6.36	1.02	0.14	0.00	0.05	0.33	0.43
3	Багануур	Бодит тоо	1	25	3	0	0	1	0	2
		10000 хүн амд	0.3	8.6	1.0	0.0	0.0	0.3	0.0	0.7
4	Чингэлтэй	Бодит тоо	3	129	21	0	0	0	4	5
		10000 хүн амд	0.21	9.20	1.50	0.00	0.00	0.00	0.29	0.36
5	Сүхбаатар	Бодит тоо	4	123	19	0	2	2	5	16
		10000 хүн амд	0.28	8.66	1.34	0.00	0.14	0.14	0.35	1.13
6	Сонгинохайрхан	Бодит тоо	1	294	47	3	3	4	9	23
		10000 хүн амд	0.03	8.60	1.38	0.09	0.09	0.12	0.26	0.67
7	Хан-Уул	Бодит тоо	5	158	21	3	1	3	3	14
		10000 хүн амд	0.20	6.36	0.85	0.12	0.04	0.12	0.12	0.56
8	Налайх	Бодит тоо	0	35	6	0	0	0	2	4
		10000 хүн амд	0.00	8.77	1.50	0.00	0.00	0.00	0.50	1.00
9	Багахангай	Бодит тоо	0	1	1	0	0	0	0	0
		10000 хүн амд	0	2.26	2.26	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бүгд		Бодит тоо	21	1207	178	13	6	14	42	100
		10000 хүн амд	0.13	7.46	1.10	0.08	0.04	0.09	0.26	0.62

**Улаанбаатар хотод бүртгэгдсэн хорт хавдрын нас баралт,
өвчний ангиллаар, дүүргээр, 2023 он**

№	Дүүрэг		Эр бэлэг эрхтэний өмөн	Шээсний замын өмөн	Нүд, тархи ба төв мэдрэлийн тогтолцооны бусад хэсгийн өмөн	Бамбай булчирхай ба бусад дотоод шүүрлийн булчирхайн өмөн	Тодорхойгүй, хоёрдогч ба байршил заагдаагүй өмөн	Тунгалгийн, цус төлжүүлэх ба тэдгээрийн төрлийн эдийн өмөн	Бүгд
1	Баянгол	Бодит тоо	3	4	7	1	1	9	245
		10000 хүн амд	0.12	0.16	0.28	0.04	0.04	0.36	9.80
2	Баянзүрх	Бодит тоо	3	6	15	2	4	16	401
		10000 хүн амд	0.07	0.14	0.35	0.05	0.09	0.38	9.48
3	Багануур	Бодит тоо	0	1	1	1	0	2	37
		10000 хүн амд	0.00	0.34	0.34	0.34	0.00	0.69	12.70
4	Чингэлтэй	Бодит тоо	0	2	5	2	0	9	180
		10000 хүн амд	0.00	0.14	0.36	0.14	0.00	0.64	12.83
5	Сүхбаатар	Бодит тоо	0	2	4	3	0	5	185
		10000 хүн амд	0.00	0.14	0.28	0.21	0.00	0.35	13.03
6	Сонгинохайрхан	Бодит тоо	3	7	9	3	5	12	423
		10000 хүн амд	0.09	0.20	0.26	0.09	0.15	0.35	12.38
7	Хан-Уул	Бодит тоо	1	2	4	1	4	10	230
		10000 хүн амд	0.04	0.08	0.16	0.04	0.16	0.40	9.26
8	Налайх	Бодит тоо	0	0	4	0	0	1	52
		10000 хүн амд	0.00	0.00	1.00	0.00	0.00	0.25	13.03
9	Багахангай	Бодит тоо	0	1	0	0	0	0	3
		10000 хүн амд	0.00	2.26	0.00	0.00	0.00	0.00	6.79
Бүгд		Бодит тоо	10	25	49	13	14	64	1756
		10000 хүн амд	0.06	0.15	0.30	0.08	0.09	0.40	10.85


7.3 ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ

Осол гэмтэл, гаднын шалтгаант нас баралт нь монгол хүний нас баралтын 3 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд 2023 оны байдлаар нийт нас баралтын 17.6 хувийг эзэлж байна. Зам тээврийн осол, амиа хорлолт, үйлдвэрийн осол, бусдад хорлогдсон, бусад осол, тодорхой бус гэсэн шалтгаануудаар эрэгтэй хүмүүсийн нас баралт эмэгтэйтэйгээ харьцангуй их байна.

Улсын хэмжээнд 2023 онд 10-34 насны хүүхэд, залуучуудын нас баралтын шалтгааны 58.8 хувийг осол гэмтэл, гаднын шалтгаант нас баралт эзэлж байгаа ба үүнээс 15-19 насныхны 59.0 хувь нь осол гэмтэл, гаднын шалтгааны улмаас амиа алдсан байна. Мөн 10-14 насны хүүхдүүдийн 53.3 хувь, 20-24 насны залуучуудын 68.6 хувь, 25-29 насны залуучуудын 58.4 хувь нь гаднын шалтгааны улмаас амь насаа алдсан байна.

Улаанбаатар хотод 2023 онд гадны шалтгаант нас баралтын 1864 тохиолдол бүртгэгдсэн нь нийт нас баралтын 20.9 хувийг эзэлж, өмнөх оноос 221 тохиолдол буюу 1.7 хувиар буурсан байна.

Осол гэмтлийн нас баралт, 10000 хүн амд, дүүргээр, 2023 он



Осол гэмтлийн нас баралтын шалтгаан, хувиар, 2023 он



Осол гэмтлийн гадны шалтгаант нас баралтын дийлэнх хувийг зам тээврийн осол, бусдад хорлогдсон, амиа хорлох, бусад осол эзэлж байна. Бусад осол дотор архины хордлого сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа ба 2023 оны байдлаар бусад ослын шалтгаант нас баралтын 35 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 6.0 хувиар буурсан, хөлдөлт ба осгож нас барсан хүмүүс осол гэмтлийн нас баралтын 9.0 хувь байгаа нь өмнөх оноос 0.9-өөр өссөн байна.


Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 115 тохиолдол буюу 6.2 хувийг 0-18 насны хүүхдийн нас баралт эзэлж байна.

Улаанбаатар хотод амиа хорлож нас барсан 231 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1.4 байгаа нь улсын дунджаас 0.1 хувиар бага байна. Нийт амиа хорлолтын 88.3 хувь нь эрэгтэйчүүд, 11.7 хувь нь эмэгтэйчүүд, 5,2 хувь нь өсвөр насны хүүхдүүд байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын хэлбэрээр авч үзвэл 131 тохиолдол буюу 7.0 хувийг зам тээврийн осол эзэлж байгаа бөгөөд 10 000 хүн амд 0.8 байгаа нь өмнөх оны, улсын дунджаас 0.6-аар бага байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралтыг төрлөөр харуулбал: 2023 оны байдлаар бусад тээврийн осол – 33.6%, мотоциклтой зорчигч зам тээврийн осолд орсон – 4.5%, явган зорчигч зам тээврийн осолд орсон – 61.8%- ийг тус тус эзэлж байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, насны ангиллаар, 2023 он



Хүн амын нас баралтын хэлбэр, 2019, 2023 он

Хэлбэр		2019 он			2023 он		
		Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Өвчлөл	Тоо	3739	2866	6605	3988	3093	7064
	Хувь	45.5	34.9	80.4	44.7	34.6	79.1
Амиа хорлолт	Тоо	174	30	204	204	27	231
	Хувь	2.1	0.4	2.5	2.3	0.3	2.6
Бусдад хорлогдсон	Тоо	135	24	159	122	11	150
	Хувь	1.6	0.3	1.9	1.4	0.1	1.7
Байгалийн хүчинд өртөх	Тоо	86	34	120	129	40	169
	Хувь	1.0	0.4	1.5	1.4	0.4	1.9
Зам тээврийн осол	Тоо	136	52	188	95	36	131
	Хувь	1.7	0.6	2.3	1.1	0.4	1.5
Архины хордлого	Тоо	384	115	499	499	159	658
	Хувь	4.7	1.4	6.1	5.6	1.8	7.4
Хий уурын хордлого	Тоо	46	13	59	75	52	127
	Хувь	0.6	0.2	0.7	0.8	0.6	1.4
Тодорхой бус шалтгаан	Тоо	187	59	246	200	67	267
	Хувь	2.3	0.7	3.0	2.2	0.8	3.0
Бусад осол	Тоо	118	14	132	114	17	131
	Хувь	1.4	0.2	1.6	1.3	0.2	1.5

[illegible]

9.3. Халдварт бус өвчлөл

Үзүүлэлт		Улс	УБ	Хүйс		Тогтмол хаягаар								
				Эр	Эм	БГД	БЗД	СХД	СБД	ХУД	ЧД	НД	БНД	БХД
Нийт халдварт бус өвчлөл	Бодит тоо	3757287	1615759	622664	993095	284527	402246	304747	232280	179862	107547	62993	15306	4959
	10 000 хүн амд	10690.1	9982.7	8217.9	12258.9	11384.2	9513.65	8917.22	16358.8	7242.31	7667.44	15784.4	5253.75	11222
ЗССӨ	Бодит тоо	465746	175868	62398	113470	37167	44822	29745	24944	17180	11061	8345	1478	1126
	10000 хүн амд	1239.5	1086.6	823.5	1400.7	1469.1	1026	871.3	1762.3	665.4	811.6	2073.9	510.9	2546.3
АЗӨ	Бодит тоо	653143	224889	104441	120448	43816	51257	33233	40911	28354	14963	8993	2493	869
	10000 хүн амд	1822.6	1389.4	1378.4	1486.8	1732	1173.4	973.4	2890.4	1098.1	1097.9	2234.9	861.8	1965.1
Хавдар	Бодит тоо	67648	39139	12712	26427	8754	9183	7540	4541	4850	2763	868	575	65
	10000 хүн амд	179.9	241.8	167.8	326.2	346	210.2	220.8	320.8	187.8	202.7	215.7	198.7	146.9
Осол, гэмтэл гадны шалтгаант өвчлөл	Бодит тоо	261536	171947	95791	76156	33141	40801	39413	17758	19147	15439	4258	1721	269
	10000 хүн амд	696.1	1062.3	1264.2	940.1	1310	934	1154.4	1254.6	741.6	1132.8	1058.2	595	608.3
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Бодит тоо		274859	102599	172260	47471	76143	48696	41322	24721	19436	13533	2860	677
	10000 хүн амд		1698.2	1354.1	2126.4	1876.5	1743.1	1426.4	2919.5	957.4	1426.1	3363.2	988.7	1530.9
Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	Бодит тоо		162115	38920	123195	24560	35636	37384	25711	19818	10113	7024	1269	600
	10000 хүн амд		1001.6	513.7	1520.7	970.8	815.8	1095	1816.5	767.5	742	1745.6	438.7	1356.8

9.4. Нас баралт

Үзүүлэлт	Улс	УБ	Хүйс		Тогтмол хаягаар								
			Эр	Эм	БГД	БЗД	СХД	СБД	ХУД	ЧД	НД	БНД	БХД
Нийт нас баралт	17533*	8928	5920	3310	1028	1801	1834	833	886	902	258	181	16
Амиа хоролсон/	498	163	224	42	18	45	37	16	23	17	4	3	0
Зам тээврийн осол	475	91	65	26	13	19	20	9	14	10	5	1	0

9.5. Өсвөр насны охидын төрөлт

Үзүүлэлт	Улс	УБ	Тогтмол хаягаар										
			БГД	БЗД	СХД	СБД	ХУД	ЧД	НД	БНД	БХД		
Өсвөр насны охидын төрөлтийн түвшин	Бодит тоо	2098	784	56	199	258	61	78	76	41	12	3	
	Өсвөр насны 1000	20.8	20.3	9.7	17.9	24.7	12.6	11.4	16.7	32.4	29.3	30.2	
	эмэгтэйд												

15-19 насанд тооцсон үзүүлэлт


9.6. Жирэмснээс сэргийлэх аргын хэрэглээ

ЖСА-ийн Орчин үеийн хэрэглээ	УБ	БГД	БЗД	СХД	СБД	ХУД	ЧД	НД	БНД	БХД	Тосгоны ЭМТ	ТЗТЭ
		24572	43574	55172	20027	41083	8472	3121	4340	765	1660	2655
Эм, бэлдмэл	36339	3615	7556	8765	3479	9482	1754	499	284	376	278	271
Тариа	14606	905	2959	5216	931	2607	711	552	347	97	150	131
Суулгац	12529	1052	1590	4022	813	2302	939	367	987	186	96	167
Бэлгэвч	65958	10785	15402	11496	7154	12444	2058	491	1365	102	423	988
Ерөндөг	39374	3076	8063	13041	3410	7324	1186	657	1285	34	474	425
Стерилизаци	4033	348	571	1591	290	450	156	275	72	0	31	17
Бусад	36141	4791	7433	10681	3950	6474	1668	280	0	0	208	656

9.7. Товлолын дархлаажуулалтын хамралт /0-2 нас/, Immunization

Дархлаажуулалт	УБ	БГД	БЗД	СХД	СБД	ХУД	ЧД	НД	БНД	БХД
В вирус хепатитын эсрэг сэргийлэх тарилгын төрөх тун	99.7	100			100	100		100	99.8	
СХТ + Геп В +ХиВ-ийн эсрэг сэргийлэх тарилга III тун	95.3	94.1	97.7	96.2	96.7	93.6	92.7	89.1	95.7	100
Халдварт саагийн эсрэг сэргийлэх тарилга III тун	95.6	92.1	97.9	96.2	96.4	94.9	92.7	89.2	95.7	100
Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилга I тун	94.8	92.7	96.2	96.7	96.7	93.8	90.8	90.0	94.2	93.4
А вирус хепатитын эсрэг сэргийлэх тарилга II тун	94.1	91.9	95.0	96.4	96.5	93.1	90.8	91.5	93.4	94.5
Пневмококкийн эсрэг сэргийлэх тарилга III тун	94.5	92.4	96.0	96.7	96.2	93.5	90.2	89.9	93.7	93.4

Товлолын дархлаажуулалт, вакцины хамралт 0-15 насанд тун тунгаар, (2023 он)



9.8. Хүний нөөц

Үзүүлэлт		Байршлаар										
		Улс	УБ	НЭМГ-ын харьяа ЭМБ	ХХЭМБ	ДЭМТ	ӨЭМТ	НЭ	АГ	Тосгон	НЭМГ-ын харьяа бусад эмнэлгүүд	НЭМГ-т мэдээ ирүүлдэг бусад эмнэлгүүд
Нийт ажиллагсад	Бодит тоо	66266	32190	26213	11968	2615	2440	1379	779	113	697	4059
	10000 х/а	189.1	196.1	159.7	72.9	15.9	14.8	8.4	4.7	0.7	4.2	24.7
Эмч	Бодит тоо	11568	9856	6924	3961	760	846	396	175	29	145	612
	10000 х/а	33	60.1	42.2	24.1	4.6	5.1	2.4	1.1	0.1	0.9	3.7
Сувилагч	Бодит тоо	7365	7902	4556	1736	702	786	430	151	23	176	552
	10000 х/а	21	48.2	27.7	10.6	4.3	4.7	2.6	1.0	0.1	1.1	3.4
Шүдний эмч	Бодит тоо	4114	1545	1463	1346	48	0	8	0	1	5	54
	10000 х/а	11.7	9.4	8.9	8.2	0.3	0.0	0.05	0.0	0.0	0.1	0.3
Эм зүйч	Бодит тоо	1162	2867	2398	2297	36	0	21	10	1	8	25
	10000 х/а	3.3	17.4	14.6	14.0	0.2	0.0	0.1	0.1	0.0	0.04	0.15

9.9. Эмнэлгийн орны тоо

Тайлан	Эмнэлгийн тасгаар																					
	Дотор	Мэс засал	Төрөх	Эмэгтэйчүүд	Хүүхэд	Халдварт	Арьс	Сүрьеэ	Мэдрэл	Сэтгэц	Гэмтэл	Нефролог	Уролог	Эрчимт эмчилгээ	Нүд	Чих, хамар хоолой	Эрүү нүүр	Хавдар	Уламжлалт эмчилгээ	Хөнгөвчлөх эмчилгээ	Бусад	Бүгд
БГДЭМТ	65	35	0	0	196	0	0	0	60	0	0	0	0	12	0	0	0	0	25	12	0	405
СХДЭМТ	170								45					10						10		235
ХУДЭМТ	60								26					2						2		90
ЧДЭМТ	100	25			80																	
НДЭМТ	55	23	14	12	32	6	2	6	15					6					20	13	23	227
БНДЭМТ	51	49	35		44	10			17					2					35	10		253
Багахангай	11				6	2															3	22
Дүүргийн ЭМТ	512	132	49	12	358	18	2	6	191	0	0	0	0	39	0	0	0	0	88	51	23	1484
СХНЭ	74	35			130				35		35			22						20	14	365
СБНЭ	144	25			120				50					11				5		5		360
БЗНЭ	164	30			130									14						20		358
ХУНЭ	71	21			80				54		4			10						15		255
Дүүргийн НЭ	453	111	0	0	460	207	0	0	139	0	39	0	0	57	0	0	0	5	0	60	14	1450
Амгалан АГ			140	30	20									10								200
Өргөө АГ			230	100	23									10								363
Хүрээ АГ			93		10									5								108
Амаржих дүн	0	0	463	130	53	0	0	0	0	0	0	0	0	25	0	0	0	0	0	0	0	648
Хонхор	9				6																	15
Гачуурт	15				2																	17
Жаргалант	12		1		2																	15
Туул	10				5																	15
Тосгон нийт	46	0	1	0	15	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	2	62
Энэрэл	80													4							8	92
ЦТЭ	105	90			50		25		40		90	30		10					20	4	56	520
ТЗНЭ	100	20		15	28				40					7	2	5			20		3	240
НЭМГ дүн	1296	353	513	157	886	225	27	6	410	0	129	30	0	142	2	5	0	10	128	115	106	4496

